Газар ашиглалтыг төлөвлөх нь тогтвортой байдлын замд орох гол арга юм. Газар ашиглалтыг төлөвлөхдөө дээрээс доош нь гэсэн зарчмаар төлөвлөх албагүй боловч газар ашиглалтыг удирдах, хамгийн тохиромжтой газар ашиглалтын хувилбарыг сонгох, хамрах хүрээ, хэмжээг нь тогтоох зэрэгт шийдвэр гаргагчдын оролцоо, дэмжлэг чухал байдаг. Хэдийгээр газар ашиглагч нарыг хэлэлцүүлэгт хамруулан нэгдсэн үр дүнд хүрэх нь чухал боловч шийдвэр гаргагч, мэргэжлийн болон техникийн ажилтнууд нь төлөвлөгөөний бүтцүүдийг холбож өгдөг гол үүрэгтэй (FAO/UNEP 1999).

Газрын нөөцийн төлөвлөлт нь хүмүүсийн хэрэгцээт газрын нөөцийг тогтвортой ашиглах үйл ажиллагааг системтэй дахин давтан төлөвлөх процесс юм. Төлөвлөлтийн явцад

байгаль, нийгэм, эдийн засаг, бүтэц зохион байгуулалт, эрх зүйн боломж, хязгаарлалтыг үнэлэн хамгийн тохиромжтой, тогтвортой газар ашиглалтыг тодорхойлж өгнө (FAO/UNEP 1999).

“Нарлаг Буянт ухаа” төслийн талбар нь ерөнхий төлөвлөгөөний газар зохион байгуулалтын бүсчлэлийн цэцэрлэгт хүрээлэнгийн бүсэд 80 гаруй хувь, 10 орчим хувь нь үйлдвэр худалдааны бүсэд, 5 орчим хувь нь өндөр орон сууцны бүсэд, үлдсэн 5 хувь нь нам давхрын орон сууцны бүсэд тус тус хамаарч байна.


Мөн “Шинэ Яармаг” хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний газар зохион байгуулалтын бүсчлэлээр нийт талбайн 40 орчим хувь нь холимог үйлдвэрийн бүсэд, 30 гаруй хувь нь нам давхрын орон сууцны бүсэд үлдсэн хувь нь сул чөлөөтэй бүсэд хамаарч байна



Зураг 4. Шинэ Яармаг хорооллын ГЗБ-ын бүсчлэлтэй харьцуулсан байдал (НЕТГ 2011).

“Нарлаг Буянт Ухаа” хорооллын ГЗБТ-ийн зураг төслийн тооцооллоор төсөлд хамрагдахгүй нэгж талбар 2.51 га, төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэндийн байгууллага нийт 1.61 га, худалдаа үйлчилгээний газар 0.51 га, дэд бүтцийн

барилга байгууламжийн газар 0.29 га, орон сууц 1.86 га, амины орон сууц 1.94 га, ногоон байгууламж 7.71 га, амралт зугаалга, тоглоомын талбай 0.58 га, авто замын газар 9.24 га талбайд тус тус төлөвлөгдсөн байна.



Зураг 5. Сонгогдсон талбайд газар шинэчлэн зохион байгуулах төлөвлөлт хийгдсэнээр (Төслийн зураг төсөл 2016).

“Нарлаг Буянт Ухаа” төслийн сонгогдсон 26.4 га талбайд газар шинэчлэн зохион байгуулах төлөвлөлт хийгдсэнээр дараах өөрчлөлт гарсан.

Хүснэгт 4. Газар шинэчлэн зохион байгуулалт хийгдсэнээр гарах өөрчлөлт, экспликаци /м²-аар/ (Төслийн тайлбар бичиг 2016)

Газар ашиглалт, хамгаалалтын ангилал			Газар ашиглалт /одоо/		Төлөвлөлт хийгдсэнээр		Зөрүү /м ² /
			м ²	Хувь	м ²	Хувь	
Нийт			264418	100%	264418	100%	0
Үүнээс	Хот, тосгон бусад суурин газрын ашиглалт		241405	90%	170057	64%	-71348
	Үүнээс	Барилга байгууламжийн газар	24212	9%	25216	10%	1004
		Төрийн захиргааны байгууллага	938		370		-568
		Боловсролын байгууллага	4081		15193		11112
		Эрүүл мэндийн байгууллага	920		526		-394
		Сүм хийд, шашны байгууллага	1853		1307		-546
		Худалдаа, нийтийн үйлчилгээний газар	11807		5112		-6695
		Автомашин засвар үйлчилгээний цэг	121		-		-121
		Агуулах	864		-		-864
		Уурын зуух	3628		2708		-920
		Суурьшлын газар	147414		61852		-85562
	Үүнээс	Гэр, орон сууцны хашааны газар	142063	56%	22983	23%	-
		Жижиг дунд үйлдвэрлэл эрхэлж буй газар	1444		-		119080
							-1444


			Төмс, хүнсний ногооны талбайтай	1572		852		-720	
			Амины орон сууц	-		19442		19442	
			Орон сууц	-		18575		18575	
			4 ба түүнээс доош давхар нийтийн орон сууц	2335		-		-2335	
	Үүнээс	Нийтийн эдэлбэрийн газар		69779	25%	82989	31%	13210	
		Нийтийн эзэмшлийн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлж, зүлэгжүүлсэн талбай		186		77146		76960	
		Тоглоомын талбай		-		5843		5843	
		Нийтийн эзэмшлийн бусад газар		69593		-		-69593	
	Зам, шугам сүлжээний газрын ашиглалт			20714	9%	92545	35%	71831	
	Үүнээс	Авто замын газар		6611		92354		85743	
		Үүнээс	Авто тээврийн хэрэгслийн зогсоолын талбай			177		-	-177
			Явган хүний ба дугуйн зам			-		35291	35291
			Хатуу хучилттай зам			6434		57063	50629
		Шугам сүлжээний газар		14103		191		-13912	
		Үүнээс	Холбоо мэдээлэл дамжуулах шугам, станц			4588		-	-4588
			Эрчим хүч дамжуулах шугам, станц			2270		191	-2079
			Цэвэр ус дамжуулах хоолой			7245		-	-7245
	Усны сангийн газрын ашиглалт			2299		1%		1816	1%

Барилга байгууламжийн дэвсгэр газар 0.1 га талбайгаар нэмэгдэж, суурьшлын газар 8.6 га-гаар багасаж, нийтийн эдэлбэрийн газар 1.3 га-гаар нэмэгдсэн байна. Зам шугам сүлжээний газар 7.2 га-гаар нэмэгдэж, усны сангийн ашиглалтын газар 0.04 га-гаар багассан байна.

Төлөвлөлтийн шийдэл

Тус барилгажилтын төслийг ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн бүсчлэл, Шинэ яармаг хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон иргэдийн санал хүсэлтийг

тусган хүн амын нягтралаар тооцсоны үндсэн дээр гэр хорооллыг тохилог орон сууцны хороолол болгон өөрчлөх, хотын өнгө үзэмжийг сайжруулах, иргэдийн ая тухтай орчинд амьдрах бололцоог бүрдүүлэх, барилгажилтын нягтралыг нэмэгдүүлэн, 5-9 давхар орон сууцны барилга, 1-2 давхар жижиг сууц төлөвлөх “Нийслэл Улаанбаатар хотыг 2030 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх зорилготойгоор орон сууцны хорооллын төлөвлөлтийн хүн ам, орон сууцны санг гаргав.



Зураг 6. Хот суурин газрын хөгжүүлэх тухай хуулийн дагуу төсөл хэрэгжүүлэх үе шат (mUGCUP 2015).

Хүн ам, орон сууцны төлөвлөлт: Төлөвлөгдөж буй нутаг дэвсгэрт 434 өрхийн 1594 хүн оршин сууж байгаа бөгөөд төлөвлөлтийн хугацаанд нийт 1527 өрхийн 5660 хүн ам оршин сууна. Төлөвлөлтийн хугацаанд

нийт хүн амын 94% инженерийн бүрэн хангамжтай нийтийн зориулалттай орон сууцанд, 6% амины сууц, таун хаусанд суухаар төлөвлөв. Нэг хүнд ногдох сууцны болон ашигтай талбайг нормоор тооцож гаргав.

Хүснэгт 5. Барилгажилтын тодорхойлолт (Төслийн тайлбар бичиг 2016)

№	Барилгын нэр	Барилгын хэмжээ /м2/	Давхрын тоо	Барилгын талбай /м2/	Тоо ширхэг	Айлын тоо	Хүн ам
Нийтийн зориулалттай орон сууц							
R1	Орон сууц	336.7	9	3030.3	1	36	133
R2	Орон сууц	540	9	4860	7	365	1351
R3	Орон сууц	540	9	4860	9	469	1735
R4	Орон сууц /үйлчилгээтэй/	2.4	9	21.6	2	73	270
R5	Орон сууц	810	15	7290	1	122	451
R6	Орон сууц /үйлчилгээтэй/	480	9	4320	1	39	144
R7	Орон сууц	480	9	4320	3	139	514
R8	Орон сууц	540	9	4860	2	104	385
R9	Орон сууц /үйлчилгээтэй/	480	9	4320	1	43	159
R10	Орон сууц /үйлчилгээтэй/	540	9	4860	1	48	178
Нийт		4749.1		42741.9	28	1438	5321
Амины орон сууц							
H1	Амины сууц	120	2	240	12	13	48
H2	Залгамал амины сууц	80	2	160	58	58	215
H3	Шаталсан амины сууц	80	2	160	18	18	67
Нийт		280		560	88	89	329
НИЙТ						1527	5650

Архитектур, орон зайн төлөвлөлтийн нөхцөл, эдийн засгийн үзүүлэлтүүд нь хүн ам, нутаг дэвсгэрийн хэмжээ, барилгажилтын дундаж

давхар, барилгын суурийн талбай, барилгын шалны талбай, ногоон байгууламжийн хэмжээ, хүн амын нягтрал, авто замын нягтрал юм.



Зураг 7. Архитектур, орон зайн төлөвлөлт (Төслийн зураг төсөл 2016).

Төлөвлөлтөөр иргэдээс авсан саналын дагуу архитектур, орон зайн 4 бүс болгон төлөвлөсөн. Амины орон сууцны бүс, орон сууцны бүс, сургууль цэцэрлэгийн бүс, худалдаа үйлчилгээний бүсүүд төлөвлөсөн.

Амины орон сууцны бүсэд гурван төрлийн сууц төлөвлөсөн бөгөөд эдэлбэр газартай нэг айлын амины орон сууц /single house/, эдэлбэр газартай амины нийлмэл сууц /town house/, эдэлбэр газаргүй амины давхарлаг сууц /terrace house/ гэсэн сууцууд байна. Давхарлаг амины сууцыг төлөвлөлтийн талбайн баруун талд байгаа газрын налууг ашиглан төлөвлөсөн.

Орон сууцны бүс нь нийтийн зориулалттай орон сууц, үйлчилгээтэй орон сууц гэсэн 2 төрөлтэй, хүн амын эрүүл аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлсэн ногоон байгууламж, гадна тохижилттой бүс байна.

Сургууль цэцэрлэгийн бүс нь таталцах хүрээний дагуу төлөвлөлтийн талбайн төв дунд хэсэгт байрлаж байгаа нь нэн таатай юм. Төлөвлөлт хийгдэж буй талбарт 791 хүүхдийн цэцэрлэг, 1130 хүүхдийн хэрэгцээ гарч байна. Сүүлийн жилүүдэд нийслэлд тулгарч буй гол асуудлын нэг нь сургууль, цэцэрлэгийн хүртээмжийн асуудал байгаа бөгөөд энэ асуудлыг шийдэх зорилгоор одоо байгаа хуучин цэцэрлэгийн хүчин чадлыг нэмж өргөтгөн, 640 хүүхдийн хүчин чадалтай сургуулийг нэмж төлөвлөсөн. Худалдаа үйлчилгээний бүсийг төлөвлөхдөө худалдаа соёл, ахуйн үйлчилгээний барилга байгууламжийн хүчин чадлыг талбарын хүрээнд хангалттай байхаар

хүн ам, хүүхэд залуучуудыг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүднээс хүртээмжтэй байхаар төлөвлөсөн. Талбайн зүүн болон хойд талд буюу одоо байгаа Нисэхийн эцэс хүрэх авто зам мөн шинээр 2030 он хүртэл Улаанбаатар хотыг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан хэвтээ тэнхлэгийн авто зам дагуу байршуулан төлөвлөсөн.

Гудамж, зам тээврийн сүлжээний төлөвлөлт: Хот, тосгоны нутаг дэвсгэрт, хот байгуулалт-орон зайн зохиомжийн төслийг боловсруулахдаа хот, тосгоны гудамж, зам тээврийн сүлжээг нарийвчлан тогтоож гол болон туслах гудамж замуудыг хооронд нь нягт уялдуулан төлөвлөв. Гудамж замын сүлжээг одоо байгаа авто замыг үндэслэн төлөвлөсөн. Хот, тосгоны гудамж, зам тээврийн сүлжээг бүрдүүлэх үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, унадаг дугуйн зам, хөдөлгөөн тусгаарлах зурвас, аюулгүйн тойрог, ногоон байгууламж, явган хүний гарц, газар доорх инженерийн байгууламж, гадаргуугийн ус зайлуулах шуудуу, дамжуулах байгууламж зэргийг хамруулан иж бүрнээр төлөвлөсөн. Авто замын төлөвлөлтийг хийхдээ 6.4-7м өргөнтэй хотын болон хорооллын чанартай замуудыг төлөвлөсөн.

Ногоон байгууламжийн төлөвлөлт: Хүн амд шаардагдах ногоон байгууламжийн хэрэгцээг Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэмд заасны дагуу

нэг хүнд 12 м² байхаар тооцож төлөвлөх шаардлагатай боловч газрын нөөцийн боломжит нөхцөл туйлын хомс учир хотын чанартай нийтийн хэрэгцээний ногоон байгууламж, хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлт хийнэ.

Нийтийн хэрэгцээний ногоон байгууламжид: Хот, тосгоны нийтийн хэрэгцээний зориулалттай цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт төгөл, орон сууцны доторх хорооллын чанартай цэцэрлэгт хүрээлэн, цэцэрлэгт талбай, цэцэрлэгт гудамж, болон зүлэгжүүлсэн зам талбай хамрагдана.

Хязгаарлагдмал зориулалттай цэцэрлэгжүүлэлтэд: Сургууль, цэцэрлэг, ясли, эмнэлгийн байгууллага, авто болон төмөр замын барилга байгууламжийн хамгаалалтын зурвас, иргэн олон нийтийн барилгын эдэлбэр газрын цэцэрлэгжүүлэлт багтана.

Ногоон байгууламжийн цэцэрлэгжүүлэлтийн ажлын бүрэлдэхүүн хэсэг нь зүлэгжүүлэлт юм. Энэхүү үйл ажиллагаа тарих зүлгийн төрөл зүйл, арга технологиос ихээхэн хамаарна. Зүлэгжүүлэлтийг барилгын хаяавч дагуу болон тохижилт хийгдэх талбайд технологийн дагуу хийнэ.

Төсөл хэрэгжүүлэх арга хэмжээ: “Нарлаг Буянт Ухаа” талбарын хувьд барилгажилтын төслийн хэрэгжүүлэх үе шатыг 2 үе шатаар төлөвлөн хэрэгжүүлэх юм. Эхний ээлжийн иргэдийн саналд тусгасны дагуу төслийн талбарын зүүн урд хэсгийн өрхийн газрыг чөлөөлөн 7 нийтийн зориулалттай 9 давхар орон сууцны барилгыг барьж ашиглалтад оруулахаар төлөвлөсөн. Төслийг хэрэгжүүлэхдээ эхний ээлжийн айл өрхүүдэд олгох нөхөн олговрыг Нийслэлийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/851 дугаар захирамжийн хавсралтын дагуу авто замын трасст орсон өрхүүдэд ногдуулсан нөхөн олговрын хэмжээгээр дундаж нэг өрхөд 60.0 сая төгрөг байхаар тооцож гаргасан ба цаашид төслийг хэрэгжүүлэхэд эхний ээлжийн ашиглалтад орсон барилгад дараалан орохоор төсөөлсөн. Тус барилгад 469 айлын орон сууц, 1800м² талбай бүхий худалдаа, үйлчилгээний барилга ашиглалтад орно. Төслийн талбар нийтийн зориулалттай орон сууцанд орох айл өрхүүдийг дунджаар 70м² байранд орохоор тооцсон. Үр ашгийн тооцоог харгалзан үзэж тухайн байршилд байх айл өрхүүдийн амьдрах нөхцөлийг дээшлүүлэх, тав тухай байдлыг хангах үүднээс орон сууцны талбайн м²-г харьцангуй өндрөөр тооцсон юм.

Дүгнэлт

“Нарлаг Буянт Ухаа” төслийн талбар нь байгалийн тогтцын хувьд тэгш гадаргуутай нийгэм, эдийн засаг орчны нөхцөл байдал нь төсөл хэрэгжүүлэхэд нэн тохиромжтойгоос

гадна иргэдийн амьдралын хэв маяг, амьжиргааны төвшин, тэдний оролцооноос ч мөн хэрэгжих боломжтой нь харагдсан юм. Судалгааны үндсэн үзүүлэлт болох иргэдийн судалгаанд хамрагдсан байдлаас хархад 90% орчим байгаа нь иргэд газар шинэчлэн зохион байгуулах үйл ажиллагаанд хамрагдах, өөрсдийн амьдарч буй орчин тойрноо сайжруулах хүсэл сонирхол их байна гэж дүгнэж байна. Судалгааг боловсруулахдаа Монгол улсад одоо мөрдөгдөж буй хот төлөвлөлт, газар зохион байгуулалт, барилгын норм, хууль дүрэм, журам, зааврыг мөрдлөг болгон анализ хийж боловсруулсан. Энэхүү судалгаа нь урьд өмнө нь нийслэлийн хэмжээнд хийгдэж байсан төсөл хөтөлбөрүүд, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний судалгаанаас илүү нарийвчилсан үр дүнтэй судалгаа болсон.

Газар шинэчлэн зохион байгуулах арга нь бүхэлдээ иргэдийн оролцоонд тулгуурласан, тэдний идэвхтэй үйл ажиллагааны үндсэн дээр үр дүнд хүрэх ажил болохоор иргэд маш идэвхтэй оролцож төслийн үйл ажиллагаа, үр дүнг маш эерэгээр хүлээн авсан.

Газар шинэчлэн зохион байгуулах үйл ажиллагаа дараах давуу талуудтай.

- Иргэд амины орон сууц барих санхүүгийн эх үүсвэргүй, зээл авах болон зээлээ төлөх боломжгүй бол шууд төлбөргүйгээр газрынхаа нэг хэсгийг төлбөрийн хэрэгсэл болгож амины орон сууц барих санхүүгийн эх үүсвэрээ шийдэх боломж бүрдэнэ.
- Иргэд өөрийн газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, орчин үеийн шаардлагад нийцсэн эрүүл ахуйн шаардлага хангахуйц орон сууцтай болно.
- Улсын төсвийн хөрөнгийг хамгийн бага хэмжээгээр зарцуулж, иргэдийн өөрсдийн хүсэл санаачилгын дагуу өөрсдийн хөрөнгөөрөө шийдэх боломж бүрдэж, жижиг дунд үйлдвэрийг дэмжих, жижиг дунд бизнес эрхлэгчдэд хөгжих боломжийг бүрдүүлж өгнө.
- Иргэд өөрсдөө ч эвлэж нэгдээд энэ ажлыг хийж болох бөгөөд сонгосон талбайд энэхүү төслийг хэрэгжүүлснээр цэвэр бохир усны шугам татаж, автомашин, явган хүн зорчих хатуу хучилттай замтай, ойр орчмын хүүхэд хөгшид нарлах цэцэрлэг байгуулах талбайтай, тав тухтай орчинд амьдрах боломж бүрдэх юм.

Талархал

Энэхүү судалгааны ажлыг хийхэд тусалж дэмжсэн “IZMON” ХХК-ний ерөнхий архитектор С.Ууганбаяр болон судалгааны багийн хамт олонд баярлалаа. Мөн багш доктор Г.Гантулга, НЕТГ-ийн мэргэжилтэн А.Золжаргалд баярлаж талархсанаа илэрхийлье.

Номзүй

БОАЖЯ, 2016, Агаарын бохирдол нийтлэл, Цахим хуудас: www.mne.mn /2016-11-01-нд хандсан/.

Болормаа Б ба Буяндэлгэр М, 2014, Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргазүй, х. 12-14, Улаанбаатар.

Буяндэлгэр М, 2016, Газар дахин төлөвлөлтөд тулгамдаж буй газрын менежментийн шийдвэрлэх асуудал. Докторын зэрэг горилсон бүтээл, Хөдөө Аж Ахуйн Их Сургууль, Монгол улс.

Жайка/Мацүй Минорү, 2015, “Монгол улсын хот байгуулалтын салбарын чадавхыг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шат” /mUGCUP2/. Улаанбаатар.

МУИХ, 2016, 19 дүгээр тогтоол “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Улаанбаатар.

mUGCUP2, 2015, “Хот суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагааны тогтолцоо”-ны аргачлал. Улаанбаатар.

НЕТГ, 2011, “Яармаг, Нисэх орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” , Улаанбаатар.

НЕТГ, 2013, “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх чиг хандлага” , Улаанбаатар.

НИТХ, 2015, Тогтоолын дугаар 23/02 “Газар шинэчлэн зохион байгуулах үйл ажиллагааны журам” , Улаанбаатар.

Нийслэлийн Өмчийн Харилцааны Газар, 2015, *Кадастрын мэдээллийн сангийн зураг*, Улаанбаатар.

НЗДТГ, 2015, Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс, *Газар шинэчлэн зохион*

байгуулах амины орон сууцтай болох журмыг баталлаа нийтлэл, Цахим хуудас: www.zasag.mn /2016-11-11-нд хандсан/

НСГ, 2015, *Нийгмийн хөгжилд нийслэл хотын эзлэх байр суурь*, Цахим хуудас: www.ubstat.mn /2016-11-1-нд хандсан/

Төслийн тайлбар бичиг, 2016, Иргэдийн оролцоотой газар шинэчлэн зохион байгуулах “Нарлаг Буянт Ухаа” төсөл “IZMON” ХХК, Улаанбаатар.

Chou, T.C. and Shen, S.K. 1982, Urban Land Readjustment in Kaohsiung. In Doebele, W.A., ed., Land Readjustment: A Different Approach to Financing Urbanization, Massachusetts: D.C. Health and Company, Lexington Books, USA. 65-90..

FAO, 1993, Guidelines for land-use planning (Rome)

FAO/UNEP, 1999, The Approach – Facing the Challenge.

GTZ and Wiesbaden, 1999, Land Use Planning

JICA/TC, 2016, “Land Readjustment in International Perspectives”, Research Institute of Metropolitan Policies, Inc.

Nishiyama Y., 1986, Western influence on urban planning administration in Japan: focus on land management. In: Nagamine, H (Ed.), Urban Development Policies and Programmes, Focus on Land Management. Japan United Nations Centre for Regional Development, Nagoya, Japan, 315-355.

Sunsun, 2013, Газар дахин төлөвлөлтийн нөхөн олговрыг тооцох асуудал Цахим хуудас: <http://sunsun.blog.gogo.mn> /2016-11-18-нд хандсан/.

БИЗНЕСИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАХ ЗЭЭЛД ОРОН ЗАЙН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АСУУДАЛ /БАНКНЫ САЛБАРЫН ЖИШЭЭН ДЭЭР/

Цогтдэлгэр.Г¹, Батцэнгэл.В¹, Бямбахуу.Г¹

¹Монгол Улсын Их сургууль, Шинжлэх Ухааны Сургууль, Газарзүйн тэнхим, Улаанбаатар, Монгол Улс

ЭШӨ-ийн цаглабар:

Хүлээн авсан огноо: 21/11/2016

Хэвлэхийг зөвшөөрсөн огноо:

23/01/2017

Түлхүүр үгс: Арилжааны банк, Мэдээллийн сан, Орон зайн загварчлал, Газарзүйн мэдээллийн систем.

Keywords: Commercial bank, spatial modeling, geographic information system

Зохиогчтой холбогдох цахим шуудан:

share.quick30@gmail.com

ХУРААНГУЙ

Бизнесийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд өнөөгийн даяарчлалын нийгэмд зах зээлийн хамрах хүрээ тэлэхийн хэрээр орон зайн эрэлт нийлүүлэлтийн ерөнхий хандлагыг шинэлэг арга зүйгээр тодорхойлох зайлшгүй шаардлага бий болж байна. Өнөөгийн бизнесийн байгууллагын удирдлага, санхүү, маркетинг, менежментийн мэргэжилтнүүд нь зах зээлийн шинжилгээ судалгааг санхүү төсөв талаас илүү тооцдог нь тухайн бизнесийн байгууллагын хувьд хэт нэг арга барилаар хандсан явцуу хүрээлэлд оруулан, сул талыг үүсгэж байна. Газарзүйн орон зайн шинжилгээг олон улсын хувьд эдийн засаг, маркетинг, эрүүл мэнд, боловсрол зэрэг бүхий л салбарт орон зайн шинжилгээ хийж өөрсдийн үйл ажиллагаанд нэвтрүүлсээр ирсэн. Харин манай орны хувьд энэ талын судалгаа орхигдсоор байгаа төдийгүй эдийн засаг тэр дундаа банкны зах зээлийг орон зайн үүднээс судлах нь тухайн салбарын болоод шинжлэх ухааны хувьд ач холбогдолтой юм. Манай улсад банкны зах зээлийн талаар маркетинг, менежментийн салбарт судалсан боловч зах зээлийн орон зайн хувьд төдийлөн судлагдаагүй байгаа аж. Энэхүү загварчлалаар банкны салбарын байршил, түүний оновчтой байдлыг үнэлэх, АТМ байрлалуудыг зөв оновчтой тогтоох, хэрэглэгчийн зах зээл, маркетингийн судалгааг илүү нарийн төвшинд хийх боломжтой. Орон зайн мэдээллийн сангийн үндсэн суурь санг бүрдүүлэн, Зах зээлийн өрсөлдөөний тооцоолуудыг орон зайн хувьд гаргах, БИГ ДАТА буюу байгууллагын мэдээллийн санг орон зайн мэдээлэлтэй хослуулан ашиглах зэргээр орон зайн шинжилгээ хийх боломжтой юм. Арилжааны банкны салбар, бүтэцтэй холбоотой нарийн мэдээлэл нууцлалын зэрэгтэй тул түүврийн арга ашиглан арилжааны банкнуудыг /Хаан банк, Голомт банк/ сонгож тухайн банкны мэдээллийн санг үүсгэхийн тулд банканд үйлчлүүлж байгаа харилцагч нараас анкетын судалгааг /450 харилцагч нар/ авч мэдээллийн санг үүсгэж, тухайн мэдээллийн санг орон зайн мэдээллийн сантай холбон загварчлав.

ABSTRACT

It seems vital to determine the general tendency of market spatiality both in demand and supply for people who run business in globalizing society. There seems great disadvantages resulted when business authorities, marketing and management specialists research market potential mostly in relation to finance and budget. This creates an adverse effect on the market research. Geographical Spatial Analyse in the fields of economy, marketing, health and education tend to be widely applied in many different countries. Yet, In Mongolia, it is often neglected. Therefore, this study focuses on bringing spatial analysis into practice. There seems a limited research on spatial analyse in the chosen field in the country. By processing this simulation will be very useful for the following case: efficient locations for bank branches and ATM as well, and estimate marketing, social and financial tendencies. The study will help us to establish the fundamental data base for Geographical Information System, estimate the calculation of business competition and combine Big Data with spatial information. Due to a degree of confidentiality of commercial banks the study applied random sampling method among bank customers. Database of the bank was created based on customers' data which was collected through questionnaire. There was a model created linking collected data with spatial data. According to the study found new locations for Khan bank and Golomt banks new branches can open.

Оршил

Өнөөгийн бизнесийн байгууллагын удирдлага, санхүү, маркетинг, менежментийн мэргэжилтнүүд нь зах зээлийн шинжилгээ судалгааг нийгэм, эдийн засаг талаас нь илүү тооцдог нь тухайн бизнесийн байгууллагын хувьд сул талыг үүсгэж байна. Энэхүү судалгаа нь банкны зах зээлийн орон зайн шинжилгээний зарим асуудлыг аргазүйн хувьд гаргаж ирэх томоохон зорилт тавин судалсан болно.

Дэлхийн олон улс оронд банкны зах зээлийн орон зай шинжилгээ хийх аргазүйг боловсруулсан байдаг бөгөөд Канад, Америкийн Нэгдсэн Улс, Энэтхэг, Бразил, Хятад зэрэг улс оронд түлхүү судлагдсан байдаг. Манай улсад банкны зах зээлийн талаар маркетинг, менежментийн салбарт судалсан байдаг боловч зах зээлийн орон зайн төлөвийг төдийлөн судлаагүй.

Газарзүйн орон зайн шинжилгээг бусад орнуудын хувьд эдийн засаг, маркетинг, эрүүл мэнд, боловсрол зэрэг нийгмийн үйлдвэрлэлтийн хүрээнд хийж өөрсдийн үйл ажиллагаанд нэвтрүүлсээр ирсэн ч манай орны хувьд энэ талын судалгаа орхигдсоор байсан. Улаанбаатар хотын арилжааны банкны үйл ажиллагаа ард иргэдэд хэрхэн хүрч ажиллаж байгаа болон, тухайн салбарын ачааллыг тооцоолж, түүн дээрээ үндэслэн шинээр салбар нээх зохистой байршлыг тодорхойлон сонгох нь зах зээлийн орон зайн шинжилгээ юм.

Газарзүйн шинжлэх ухааны судалгаанд аливаа нийгмийн болон байгалийн юмс үзэгдлийн орон зайн шинжилгээ, бүс нутаг, хүн ба газрын хоорондын хамаарал, дэлхий судлалтай холбоотой судалгаа багтдаг байна. (Pattison. 1990)

Монгол улс 2015 оны байдлаар 3,018,000 хүн амтай үүний 1,372,000 нь Улаанбаатар хотод байнга оршин сууж байна (Монгол улсын Үндэсний статистикийн хороо 2015). Хүн ам ихээр төвлөрөх тусам нийслэл хотын эдийн засаг өдрөөс өдөрт тэлж байгаа бөгөөд үүнийг даган үйлчилгээний болон бизнесийн байгууллагуудын тоо өсөн нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Эдгээр байгууллагуудын байршил болон тухайн нутаг дэвсгэрт байршсан газар нь зах зээлд хүрч чадсан эсэх нь тухайн байгууллагын цаашдын хэтийн төлөвийг тодорхойлж байдаг. Бизнесийн байгууллагууд дундаас банкны салбарыг авч үзвэл: Өнөөдрийн байдлаар Монголын банкнуудын холбоонд бүртгэлтэй 14 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна (Монгол банкны холбоо 2015). Эдгээр банкнуудын зах зээлийг эзэлсэн байдал, банк хоорондын өрсөлдөх чадвар зэрэг нь бизнесийн байгууллагын хувьд оршин тогтнох тулгуур ойлголт юм. Эдгээр банкнуудын үйл ажиллагааны чиглэл нэг бөгөөд тухайн салбар нэгж бусад банкнуудын салбар нэгжтэй

харилцагчдыг татах, цаашид үргэлжлүүлэн харилцах гэх зэргээр өрсөлдөж байдаг. Орон зайн хувьд тооцоолох нь банкнуудын цаашдын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх нэн тэргүүний зорилго юм. Хаан банкны бизнес төлөвлөлтийг үзвэл: Өнөөдрийн байдлаар 91 салбар нэгж нийслэл хотод үйл ажиллагаа явуулж байна (Хаан банк 2015). Хаан банкны нэг тейлорт сард дунджаар 1600 харилцагч оногдож байна. Нийслэл хотод хаан банкны нэг салбарт дунджаар 15,000 хүн ногдож байгаа бол нэг тейлорт 3000 харилцагчдад үйлчилгээ үзүүлэх шаардлагатай болж байна (Хаан банк 2015). Салбар нэгжийг байршуулахдаа бусад банкны салбар, зах зээлд ойртох оновчтой орон зайн тооцоололт хийх шаардлагатай. Үүнийг газарзүйн шинжлэх ухааны /Нийгэм, эдийн засгийн газарзүйн /үүднээс судалж, цаашдын хэтийн төлөвийг тодорхойлно.

Банкны зах зээлийг судалснаар тухайн салбар нэгжийн үр ашгийг тооцоолж тухайн салбарын үйл ажиллагааны хүртээмж орон зайг тодорхойлох боломжтой юм. Цаашид арилжааны банк харилцагч нартаа оновчтой хүрч ажиллаж байгаа эсэхийг тодорхойлоод зогсохгүй маркетингийн үйл ажиллагааны ирээдүйн төлөвлөлтийг үр дүнтэйгээр бий болгож буй судалгаа юм. Арилжааны банкнууд энэхүү тооцооллоор зах зээлээ нарийн зурагласнаар цаашдын өрсөлдөх чадвар, үйл ажиллагааны хүрээгээ илүү оновчтой тэлэх боломжуудыг бий болгож болно.

Судалгааны зорилго, зорилт

Арилжааны банкны салбарын үйл ажиллагаа нь зах зээлд хэрхэн хүрч ажиллаж байгааг тодорхойлж, орон зайн шинжилгээгээр зах зээлийн төлөвийг илүү нарийвчлан гаргахад оршино.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлсэн.

Тухайн бизнесийн байгууллагын хувьд жишээ болгон Хаан банк болон Голомт банкны системийг сонгон авч судалж тодорхойлохыг зорилоо.

- Дээрх арилжааны банкнуудын салбар, АТМ-ны байршлуудыг тодорхойлох
- Улаанбаатар хотын нийгмийн үзүүлэлтүүдийг орон зайн статистик боловсруулалтаар дүрслэн гаргах
- Сонгон авсан банкнуудын зах зээлийн орон зайн төлөвийг тодорхойлох
- Арилжааны банк зах зээлээ тэлэх боломжит хувилбарыг гаргах


Судалгааны аргазүй, аргачлал

Энэхүү судалгааг хийж гүйцэтгэхэд арилжааны банкны мэдээллийн санг үүсгэх, мэдээллийн санг загварчлах шаардлагатай. Мэдээллийн санг байгуулахад шаардлагатай

мэдээлэл нь тухайн арилжааны банкнуудын харилцагч нарын мэдээлэл юм. Банкнуудын хэрэглэгчийн мэдээлэл нууцлалын зэрэгтэй учир, мэдээллийг олон нийтэд танилцуулж гаргах боломжгүй байдаг. Тиймээс мэдээллийг цуглуулж болох арга, аргачлал ашиглах шаардлагатай болсон. Аливаа судалгааны ажил амжилттай болох үндэс нь судалгааны зорилго зорилтод нийцсэн судалгааны арга зүйгээ зөв тодорхойлоход оршино (Макданиал ба Гейтс 2012). Үнэн зөв, хугацаа хэмнэсэн, олон хүн хамарсан мэдээллийг цуглуулах арга нь асуулгын арга юм. Асуулга судалгаа гэдэг нь хэд хэдэн хувьсагчийн тухайд тоогоор илэрхийлж болох мэдээллийг системтэй цуглуулахын тулд тодорхой цэгүүдээс ихэвчлэн цаг хугацааны тодорхой нэг мөчид мэдээлэл цуглуулан авч дараа нь уялдаа хамаарлын зүй тогтлыг шинжлэх явдал юм (Робсон 2006). Асуулгын аргыг мэдээлэл цуглуулж байгаа байдлаас хамааран анкетын болон ярилцлага хэмээн хоёр ангилна. Мэдээллийг хурдан хугацаанд, олон оролцогчийг хамрах боломжтой арга нь анкетын аргачлал юм. 2015 оны 2-р сараас 5-р сарын хооронд судалгааны хүрээнд сонгож авсан банкнуудын харилцагч нарыг хүн амын нас, хүйс, амьжиргааны төвшинд тулгуурлан харьцуулж санамсаргүй түүвэрлэн 450-н хүний мэдээллийг цуглуулан, мэдээллийн санг байгуулсан. Тухайн харилцагч нарын мэдээллийн санг байгуулж, мэдээллийн санг загварчлан, өнгөн дэвсгэрийн арга, график дүрслэл, орон зайн шинжилгээ зэргийг ашиглан боловсруулалт хийж гүйцэтгэсэн. Арилжааны

банкны мэдээллийн санг үүсгэхийн тулд нийслэлийн төвийн 6-н дүүрэг бүрээс тус тус 1 салбарыг санамсаргүй түүврийн аргаар 12 салбарыг сонгон авсан. Тухайн салбар бүрд үйлчлүүлж байгаа харилцагч нараас хагас хаалттай анкетын судалгаа авч, тухайн харилцагчийг алслагдсан зайнаас ирж байгааг тодорхойлж, орон зайн шинжилгээ хийхийг зорьсон. Мөн түүнчлэн газарзүйн мэдээллийн систем, математик статистик боловсруулалтыг голчлон ашигласан.

Анкетын аргын гол зорилго нь тухайн харилцагч нарын мэдээллийн санг байгуулж, хэдий чинээ алслагдсан газар нутгаас ирж байгааг тодорхойлон цацраг хэлбэрээр дүрслэх юм. Үүнийг орон зайн загварчлал гэх бөгөөд цацрагийн хэмээжээ урт байх тусам харилцагч нарын алслагдсан зай их байна. Цацрагийн уртыг гаргахдаа А цэг болох арилжааны банкны салбар нэгж, Б цэг нь харилцагч нарын байршил. Тухайн хоёр цэгийг холбох байдлаар зурагт тэмдэглэх бөгөөд А цэг рүү тэмүүлэх Б цэгийн харьцаа нь $A:n$ хэмжээтэй байна. А цэг рүү холбогдох Б цэг нэмэгдэх тусам А цэг дээр ачаалал нэмэгдэнэ. Мөн А цэг, Б цэг хоёрын хоорондын зай алслагдсан байдалтай буюу хол байх тусам нэгж салбарт ирэх ачаалал нь төдий чинээ ихэснэ. Арилжааны банкны үйл ажиллагаа явуулж байгаа салбарыг цайвар ногоон өнгөөр дүрсэлж, хамрах хүрээг 500м-ийн зайгаар тогтоосон, хамрагдаж чадахгүй байгаа харилцагч нарын байршилд салбар нэгжийн дутагдалтай байршил хэмээн үзэж, нээх боломжит байршил гарч ирнэ.



Зураг.1 Цацраган загвар
Эх сурвалж: Зохиогч

Мэдээллийн санд харилцагч бүрийн арилжааны банкны гишүүнчлэл, арилжааны банкнуудын салбарууд байршлаас алслагдсан байдал, тухайн харилцагчийн өөрийн оршин суугаа хаяг болон Банкны зах зээлийг судалснаар тухайн салбар нэгжийн үр ашгийг тооцоолж цаашдын өөрийн үйл ажиллагааг тэлж болох орон зайг тооцоолох боломжтой. Энэхүү судалгаа нь банк өөрсдийн харилцагч нарт бүрэн хүрч ажиллаж чадаж буй эсэхийг тодорхойлоод зогсохгүй маркетингийн үйл ажиллагааг бодитоор тооцоолох боломжийг бүрдүүлнэ. Мөн арилжааны банкнууд өөрсдийн үйл ажиллагаанд орон зайн дүн шинжилгээ хийснээр салбар нэгжийн үр ашиг, салбар нэгжид ирэх ачааллыг тооцоолох боломжтой юм.

Мэдээллийн сан

Анкетын судалгааг Хаан банкны зургаан салбар, Голомт банкны зургаан салбар байршилд нийт 6 дүүргийн 12 байршлаас авсан. Баянзүрх дүүргийн 15-р хороо болох Зүүн дөрвөн замын уулзварын хажууд байрлах Хаан банк, Голомт банкны салбар. Баянгол дүүргийн 2-р хорооны Хаан банкны салбараас, 14-р хороонд байрлах Голомт банкны салбар. Сүхбаатар дүүргийн 10-р хороонд байрлах Хаан банкны салбар, 8-р хороонд байрлах Голомт банкны салбар. Сонгино-хайрхан дүүргийн 9-р хороонд байрлах Хаан банкны салбар, 29-р хорооны Голомт банкны. Хан-уул дүүргийн 2-р хороод байрлах Хаан банкны салбар, 3-р хороонд байрлах Голомт банкны салбар дээрээс тус тус байршилд анкетын судалгааг авсан. Чингэлтэй дүүргийн 4-р хороонд байрлах Хаан банкны салбараас, 1-р хороонд байрлах Голомт банкны салбар байршлыг оролцуулан нийт 12 байршилд анкетын судалгааг авсан. Зургаан дүүргийн 12 байршлаас авсан мэдээллийг орон зайн мэдээлэлтэй холбож, мэдээллийн санг байгуулж. Тухайн мэдээллийн санг дүүрэг болгоноор нь танилцуулахад томоохон хэмжээтэй учир Баянзүрх дүүргийн Хаан банк, Голомт банкны нэг, нэг салбарыг сонгон авч

мэдээллийн сан дээр суурилсан орон зайн загварчлалыг танилцуулж байна.

Онолын хэсэг

Арилжааны банк

Монгол улсын эдийн засгийн толгой байгууллага нь Монгол банк юм. Монгол банк нь өөрийн нөөц хөрөнгийн тусламжтай эдийн засгийн эргэлтийг бий болгож байдаг. Макро эдийн засгийн төвшин, микро эдийн засгийн төвшин хоёрын уялдаа холбоог зохицуулж байдаг бөгөөд үүнийг мөнгөний бодлогын тусламжтай гүйцэтгэдэг. Төв банкны авч хэрэгжүүлж байгаа аргачлалыг мөнгөний хатуу бодлого, зөөлөн бодлого гэж нэрлэдэг. Энэ бодлогыг хэрэгжүүлэх гол байгууллага нь арилжааны банкнууд юм. Арилжааны банк гэдэг бол хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монгол банкны тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээд юм (Монгол улсын Банкны тухай хууль 2010).

Арилжааны банкны зах зээлийн үйл ажиллагаа

Монгол банкны зөвшөөрөлтэй зээл, төлбөр тооцооны үйлчилгээ, өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа буюу батлан даалт гаргах, гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах, үнэт үйл хадгалах, үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах, гадаад төлбөр тооцоо хийх, үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа, зээлийн болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг(Балж ба Мөнхдулам 2006).

Хүснэгт.1 Арилжааны банкнуудын харилцагчдад үзүүлэх үйлчилгээ

Хадгаламж	Баталгаа гаргах	Төлбөрийн картын үйлчилгээ	Mobile phone Banking үйлчилгээ
Хадгаламжийн хайрцаг	Тодорхойлт гаргах	Мэдээлэл, лавлагаа гаргах	-Овердрафт үйлчилгээ
Зээл	Үнэт цаасны арилжаа	Орлого хураах үйлчилгээ	-Интернет банк
Төлбөр тооцоо	Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах	Тэтгэвэр, тэтгэмж тавих үйлчилгээ	-Мессеж
Харилцах данс	Валют, алтны арилжаа	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ	-Телефон банк
Мөнгөн гуйвуулга	Бэлэн валютын үйлчилгээ	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр	Санхүүгийн бусад үйлчилгээ

Гадаад төлбөр тооцоо	Эскроу дансны үйлчилгээ
Батлан даалт гаргах	Лизинг, санхүүгийн түрээс

зөвлөгөө өгөх

SMS Banking

Private Banking үйлчилгээ

Арилжааны банкны харилцагч нар нь нийт монгол улсын болон өөр улсын иргэн байж болдог бөгөөд эдгээр хүмүүстэй ихэвчлэн мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцооны үйлчилгээ, гадаад валютын төлбөр тооцоо зэргээр голчлон үйлчлүүлдэг байна.

Мөнгөн хадгаламж гэдэг хуулийн этгээд өөрийн хүсэлтийн дагуу мөнгөн тэмдэгтийг /мөнгөн хөрөнгийг/ тухайн банканд хадгалуулсны төлөө хүү буюу мөнгөн тэмдэгтийг нэмэн авдаг үйлчилгээг хэлдэг.

Зээл гэдэг бол банкны шаардсан болзол нөхцөлийн дагуу хуулийн этгээд өөрийн хөрөнгийг барьцаалуулан тухайн банкны хүүг төлөн бэлэн мөнгө авахыг хэлнэ.

Төлбөр тооцооны үйлчилгээ гэдэг нь тухайн үйлчлүүлэгчийн хүсэлтээр өөрт байгаа дансны үлдэгдэлд тааруулан мөнгөн тэмдэгтийг өөр дансанд шилжүүлэхийг хэлнэ. Энэ нь


Эх сурвалж: (Монгол улсын Банкны тухай хууль 2010)

өөрийн гарын үсгээр баталгааждаг бөгөөд банк хоорондын гүйлгээ ч хийж болдог.

Гадаад валютын төлбөр тооцоо гэдэг бол гадаадын улс орны мөнгөн тэмдэгтийг тухайн улсын мөнгөн тэмдэгттэй тэнцүүлэн худалдан авах болон худалдахтай холбогдох үйл ажиллагааг хэлнэ (Балж ба Мөнхдулам 2006).

Мэдээллийн сангийн дизайн

Мэдээллийн сангийн дизайныг хийхдээ биет хоорондын хамаарлын диаграммыг ашиглан энити буюу эгэл хэсгийг тодорхойлсон. Биет хоорондын хамаарлаар мэдээллийн санг бүрдүүлснээр мэдээллийн систем зөв дэс дараалалтай ажиллах боломжтой болж байгаа юм. Мэдээллийн сангийн дизайныг схем 1 дээр харуулав.



Схем 1. Мэдээллийн сангийн дизайн

Газарзүйн мэдээллийн систем

Газарзүйн мэдээллийн систем /ГМЗ/ нь бодит ертөнцөөс орон зайн мэдээлэл цуглуулах, хадгалах, хүссэн үедээ татаж аван, өөрчлөх боломжтой маш өргөн уудам мэдээллийг харуулдаг.

Газар зүйн мэдээллийн системийн хэрэглээ нь төрөл бүрийн салбарт шийдвэр гаргахад

дэмжлэг үзүүлдэг үүнд (хот төлөвлөлт, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, дэд бүтцийн төлөвлөлт, эдийн засгийн хөгжил, татвар, SWOT шинжилгээ, гэх мэт), нөөцийн менежмент, төсөвт үзүүлэх нөлөөлөл нь хүн амын чиглэсэн үйлчилгээ үзүүлэх, төрийн захиргааны болон бусад чухал салбарууд хурдан хайх, оновчтой асуудал шийдвэрлэх шийдлийг, түүнчлэн ижил

GIS системийн хооронд уялдаа шаардлагатайг харуулж байна.

Spatial Decision Support Systems /SDSS/ = Орон зайн үйл ажиллагааг дэмжих систем (Дрөж, Суба 2009)

Арилжааны банкнууд ГМС-ийг ашигласнаар дараах ач холбогдолтой. Газарзүй, хүн ам судлал дээр суурилан орон зайн загваруудыг ашиглан хэрэглэгчийн харилцан нөлөөлөл, эдийн засгийн нөхцөл, эрсдэлийг тооцоолох боломжтой. Мөн салбар бүрийн оюуны хөдөлмөр, үйл ажиллагааг хоорондоо хувиарлах удирдлагын үзүүлэлт, ашиг орлогыг нэмэгдүүлэх ашиг тустай. Эдийн засгийн урьдчилан тооцоолол, хөрш зэргэлдээх туршлагыг суралцах, нутаг дэвсгэрийг шинжлэхийн сацуу салбар хоорондын бизнесийн хамтын ажиллагааг өсгөнө. Зах зээлийн нөхцөлийг нарийн шинжилгээг хийх, бизнесийн нарийн төвөгтэй байдлыг багасгана. Өргөтгөсөн орон зайн ажлын урсгал, бизнес үйл ажиллагааг ашиглан бизнесийн үзүүлэлтийг нэг, нийтлэг үзэл бодол дээр тулгуурлан зах зээлийн ойлголтыг нэмэгдүүлнэ (Белски, Кин, Мигбулугби 1998).

Судлагдсан байдал

Сүүлийн жилүүдэд ГМС-ийн үүрэг, оролцоо олон салбар ашиглагдаж байгаа боловч банкны салбар нэгжид газарзүйн мэдээллийн систем ашиглах аргачлалыг Канадын Торонтогийн Их Сургуулийн Газарзүйн тэнхимийн Илиот, МакДоналд нар гаргасан байна. Банк, санхүүгийн салбарт газарзүйн мэдээллийн систем ашигласан орон зайн оновчтой шийдвэр гаргахад шаардлагатай. Орон зайн загварчлал нь үйлчилгээний байгууллагуудын байршил, барилга байгууламж, зам тээвэр зэргийг харгалзан үзсэнээр үйлчилгээний хүрээг тодорхойлно.

$$P_{ij} = \frac{A_j^\alpha / d_{ij}^\beta}{\sum_j (A_j^\alpha / d_{ij}^\beta)}$$

Томъёо 1 Орон зайг загварчлах аргачлал

(Эх сурвалж: Eliot Hugh MacDonald 1998)

P_{ij} – Өрхийн барилга, газар

A_j^α – Барилгажсан талбай

d_{ij}^β – Өрхийн хоорондын зай

α – Периметрийн талбайгаар бодох


β – Периметрийн талбайгаар зайг олох

Ингэж тооцоолж үзсэний үндсэн дээр бизнесийн зах зээлийг тодорхойлж тодорхой хэсэг байршуулах боломжит цэгүүдийг гаргаж ирдэг. Энэ боломжит цэг нь хэрэглэгчдийн тусгаарласан хэсэг буюу бодит эрэлт, хэрэгцээ бүхий нутаг болдог.


Канадын банкнууд шинэ салбарыг нээхдээ газар нутгийн байршил болон эрсдэлтэй талыг тооцоолж байгуулдаг. Нэгж салбарын хамрах хүрээг тооцоолж зах зээлийн үйлчлэл, санхүүгийн гүйцэтгэлийг орон зайд оруулснаар мэдээллийн систем үүсгэнэ. 1998 оноос эхлэн Канадын бизнесийн байгууллагуудад ГМС-мэдээллийг боловсруулах ажил давамгайлсан.

Бразилын Парана Фидиралын их сургуулийн загварчлал

Бразилийн Парана Фидиралын Их сургуулийн судлаач Ана Марина Карнаскиали болон Лисиени Делазани нарын аргачлал. Орон зайн хувьсагчдад хүн ам, хүн амын нягтшилт, зам тээвэр, амын амын хэтийн төлөв зэргийг голчлон авч үзсэнээр тодорхой бүс нутгийн хэтийн төлөвийг харж болдог. Ингэж авч үзсэнээр бүсийн хязгаарыг тодорхойлж тухайн бүс дотор шинэ салбар, шинэ үйлдвэрлэлт явуулах боломжийг гаргаж болдог. Орон зайг тооцоолж үзэхдээ гудамж, талбай, зам тээвэр зэргийг харгалзан үзнэ.



Зураг 2 Хүн амын нягтаршилт
(Эх сурвалж: Ana Maria Carnasciali 2010)



Кадастрийн мэдээлэл



Барилгын нөхцөл



Бохирдолын түвшин



Үер болон бусад байгалийн гамшигийн эрсдэл

Зураг 4 Банкны үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэлгээ

(Эх сурвалж: Gabriela, Laurentiu, Simona 2010)

Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэлгээг хийхдээ учирч болох байгалийн гамшиг, тухайн нутаг дэвсгэрийн бохирдолтын төвшин, барилгажсан талбай зэргийг тооцоолж үзэх нь банканд учирч болох эрсдэлийг тооцоолж зах зээлийн үнэлгээг үнэн бодитоор гаргах боломжтой.


Судалгааны үр дүн

Улаанбаатар хотын хүн амын орон зайн тархалт

Орон зайн хувьсагчдад хүн ам, хүн амын нягтшилт, зам тээвэр, хүн амын хэтийн төлөв зэргийг голчлон авч үзсэнээр тодорхой бүс нутгийн хэтийн төлөвийг харж болдог. Ингэж авч үзсэнээр бүсийн хязгаарыг тодорхойлж тухайн бүс дотор шинэ салбар, шинэ үйлдвэрлэлт явуулах боломжийг гаргаж болдог. Орон зайг тооцоолж үзэхдээ гудамж, талбай, зам тээвэр зэргийг харгалзан үзнэ (Мариа 2010). Улаанбаатар хотын хүн амыг орон зайн хувьд нь авч үзвэл:

Улаанбаатар хотын хамгийн их хүн амтай хороод болох Баянзүрх дүүргийн 5-р хороо, 16-р хороодын хүн ам 18000 орчим юм. БЗД-ын 5-р хороо Кино үйлдвэрийн хэсэг 16-р хороо нь офицерийн тойрог орно. Мөн БЗД-ын 4-р хороо, 27-р хороодын хүн ам нь 15600-15700-ын хооронд байна. Сүхбаатар дүүргийн хороодын хүн ам бусад дүүрэгтэй харьцуулбал хороод нь дундаж төвшинтэй бөгөөд 4500-10000 хооронд байна. Хан-уул дүүргийн 15-р хороо 14000 хүн амтай бөгөөд дүүргийн хэмжээнд хамгийн их хүн амтай юм. Баянгол дүүргийн 1-р хороо, 6-р хороодод 15000, 17000 хүн ам суурьшсан байгаа нь дүүрэгтээ тэргүүлж байна. Чингэлтэй дүүргийн 12-р хороо /Дэнжийн мянга/ 15000 орчим хүн амтай байгаа нь дүүрэгтээ тэргүүлж байна. Сонгино-хайрхан дүүргийн 7-р хороо, 22-р хороод 15500, 16000 орчим хүн амтай. Дээрх хороод нь дүүрэгтээ хамгийн их хүн ам суурьшсан засаг захиргааны нэгж юм. Хүн ам ихээр төвлөрсөн газрууд нь хотын төвөөс гадагш байгаа нь хотын тэлэлт гадагшаа чиглэлтэйг харуулж байна.

Улаанбаатар хотын хүн ам




Зураг 5. Улаанбаатар хотын хүн амын нягтшил, тархалтын зураг

(Эх сурвалж: Зохиогч)

Улаанбаатар хотын хүн ам, арилжааны нэмэгдэх тусам хэрэглэгч нар нэмэгдэх банкны харилцагчдын тоо хоорондын боломжтой. хамаарлын коэффициент $R=0,98$ буюу хүчтэй хамааралтай байгаа бөгөөд хүн амын тоо өсөн

График 1 Улаанбаатар хотын хүн ам, банкны харилцагч хоёрын хамаарал



(Эх сурвалж: Зохиогч)

Баянзүрх дүүргийн Хаан банкны мэдээллийн сан


БЗД-ийн 15-р хороонд байрлах 13-р хорооллын автобусны буудлын урд талд байрлах Хаан банкны салбарын харилцагчдаас 7-н асуулт бүхий хагас хаалттай судалгааг авсан. Энэхүү судалгаагаар Хаан банкны салбар, АТМ-ыг ачааллыг тооцоолох орон зайн шинжилгээ хийхийг зорьсон. Судалгааны эхний асуултаар арилжааны банкнуудын салбарууд орон зайн хувьд зах зээлд хүрч ажиллаж байгааг тодорхойлсон. БЗД-ийн Хаан банкны судалгаанд оролцсон нийт хүмүүсийн

51% нь Хаан банкны салбар 500м газарт байрласан бол 42,7% нь бусад банкны салбар 500метр, үлдсэн 6,3% банкны салбаргүй хэмээн хариулт өгсөн байна. Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд Хаан банк харилцагч нарынхаа 49% алдах эрсдэлтэй бөгөөд банкны зүгээс шинэ салбар нэгжийг байгуулж өгөх шаардлагатай байна. Нийт арилжааны банкнуудын салбарын байршил харилцагч нарт 500м зайд хүрсэн байдлаар авч үзвэл. Хаан банк 31,6%-ийг, Хас банк 11,3%, Голомт банк 12,6%, Капитал банк 3,9%, Төрийн банк 24%, Ариг 3,7%, бусад банк 6,3%-ийг тус тус эзэлсэн

байна. Салбарын байршлын орон зайн төлөвлөлт хийгдсэн байгааг тодорхойлох асуултад харилцагчдын 72% нь банкны салбар хайж 500м-1000м зайд явж байсан бөгөөд банкны салбарын байршилд орон зайн тооцоолол хийж чадаагүй байгаа нь харагдаж байна. Улаанбаатар хот доторх хүн амын ажил эрхлэлтийн байдлаас хамааран хүн амын хөдөлгөөний чиглэлийг тооцоолох асуултад нийт судалгаанд оролцсон харилцагч нарын 77,5% нь БЗД-ийн доторх хөдөлгөөн, 6,2% нь БГД-ийн хүн амын хөдөлгөөн, 6,2% нь ЧД-ийн хүн амын хөдөлгөөн, 2% нь ХУД-ийн хүн амын хөдөлгөөн, 2% нь СБД-ийн хүн амын

хөдөлгөөн, 6,2% нь СХД-ийн хүн амын хөдөлгөөнүүдийг бүрдүүлж байна.

Хаан банкны АТМ-ны орон зайн төлөвийг авч үзвэл. Судалгаанд оролцогчдын 18,2% нь банкны АТМ хайж явж байгаагүй бөгөөд 24% нь 100м-200м газар явж АТМ үйлчилгээг авдаг байна. Харин нийт харилцагчдын 42% нь 200м-500м зайд туулж үйлчилгээнд хамрагддаг байна. Үлдсэн 14% нь 1км-ээс дээш газар явж үйлчилгээг авдаг байна. Хаан банкны салбар нэгжийн орон зайн төлөв, салбарын ачааллыг тооцоолох зорилгоор харилцагч нар, салбарын байршлаас алслагдсан зай доорх зураг дээр үзүүлсэн байна.



Зураг 6. БЗД-ийн Хаан банкны харилцагч нарын байршил

(Эх сурвалж: Зохиогч)

Голомт банкны мэдээллийн сан


Голомт банкны мэдээллийн санг Улаанбаатар хотын 6-н дүүргийн салбар нэгжээс анкетын судалгаа авч байгуулсан. БЗД-ийн 13-р хорооллын 15-р хорооны зүүн дөрвөн замын хажууд байрлах Голомт банкны салбарт үйлчлүүлж байгаа харилцагч нараас анкетын судалгаа авсан. Эхний асуултаар Арилжааны банкуудын орон зайн төлөв болон зах зээлд хүрч ажиллаж байгааг үзвэл. Нийт БЗД-ийн Голомт банкны харилцагч нараас авсан судалгааны 44%-д тухайн банкны салбар 100м-500м газарт байршсан бол 48%-д бусад арилжааны банкны салбарууд байршсан бөгөөд үлдсэн 8%-д нь 500м газарт голомт банкны салбар байдаггүй байна. Хоёрдугаар асуултаар Голомт банкны үйлчилгээ харилцагч нарын байршилд оновчтой тогтоох зорилгоор алслагдсан зайг гаргасан бөгөөд оролцогчдын

84,6% нь 500м-1000м газар хайж явж байсан. Гуравдугаар асуулт болох арилжааны банкны АТМ-ийн орон зайн төлөвийг судалж үзэхэд. Оролцогчдын 12% нь 100м-200м газар явдаг, 28% нь 200м-500м зайд явдаг, 20% нь 500м-1000м зайд явдаг, 12% нь 1км болон түүнээс дээш газар явдаг байна. Үлдсэн 16% нь хайж явж байгаагүй байна.

Дөрөвдүгээр асуултаар хүн амын хөдөлгөөнийг тогтоох зорилгоо БЗД-т бусад дүүргээс ирж ачааллыг үүсгэж байгааг тодорхойлоход тухайн нутаг дэвсгэрийн хөдөлгөөн нь оролцогчдын 58%-ийг эзэлж байгаа бол ХУД, ЧД, СХД-үүд тус бүр 10%-ийг эзэлсэн. БГД, СБД зэрэг дүүргүүд хамгийн бага үзүүлэлттэй буюу 6% -тай байна. Тав дугаар болон долоо дугаар асуултын тусламжтай тухайн нутагт дэвсгэрийн хаанаас ирж тухайн салбарт үйлчлүүлж байгааг цэгээр тэмдэглэн хоорондын алслагдсан байдлаар тодорхойлсон.

Зургаа дугаар асуултаар тухайн банкны харилцагч нар давхар хэдэн банктай харилцдагийг гаргасан. Үүнд: Зөвхөн Голомт банкны үйлчлүүлэгч 13,6%-тай тэнцэх бол

45,4% нь хоёр банкны харилцагч, 22,7% нь гурван банкны харилцагч, 12% нь 4 болон түүнээс дээш банкны харилцагч болно.




Зураг 7. БЗД-ийн Голомт банкны харилцагч нарын байршил

(Эх сурвалж: Зохиогч)

Голомт банкны орон зайн шинжилгээ

Голомт банкны судалгаанд оролцсон харилцагч нарын 80,7% нь банкны үйлчилгээг авах гэж 500м-1000м хүртэл газар явж байсан. Түүнчлэн 39,2% нь Голомт банкны АТМ үйлчилгээг авах гэж 500м-1000м болон түүнээс дээш км явж байсан. Дүүрэг хоорондын шилжих хөдөлгөөн, салбар хоорондын алслагдсан зай зэргийг тооцоолж цаашид зах зээлийг тэлж шинээр салбар нээх боломжтой байршлыг үзүүлэв. Тухайн байршил харилцагч нарт банкны үйлчилгээг ойртуулж өгөх боломжтой ба харилцагч нараа алдахгүй байх давхар бодлоготой юм. Одоогийн байдлаар БЗД болон СХД-д Голомт банкны салбар шаардлагатай байгаа бөгөөд тухайн дүүргүүдэд

банкны салбар дутагдалтай байгаагаас ЧД, СБД-ачааллыг нэмэгдүүлж байна. Судалгааны үед СХД-ийн салбар бусад дүүргүүдийн салбараас ачаалал хамгийн ихтэй байсан. Түүнчлэн бусад банкны салбарын байршлыг тооцоолж үзвэл харилцагч нарыг татах илүү боломжтой юм. Банкны салбарыг байршуулахдаа тухайн дүүргийн болон нутаг дэвсгэрийн онцлогтой уялдаж байвал илүү үр өгөөжтэй. Жишээ нь: СБД-ийн иргэний бүртгэлийн салбарын ачаалал иргэний бүртгэл мэдээллийн төвийн дансанд мөнгө байршуулах гэж ачаална. Энэ нь төрийн байгууллагын хажууд байршуулсан нь оновчтой гэсэн үг биш. Тухайн байршлыг харгалзаж үзэхдээ бусад салбарын байршлыг тооцоолж үзэх нь чухал юм.




Зураг 8. Голомт банкны салбар нээх боломжит байршлууд
(Эх сурвалж: Зохиогч)

Хаан банкны орон зайн шинжилгээ

Хаан банкны салбар нэгжийн ачааллыг бууруулах боломж нь Хаан банкны зүгээс тейлорийн тоог нэмэгдүүлж, хэрэглэгч байгууллагын болон хувь хүн гэсэн байдлаар хувааж ачааллыг бууруулах арга хэмжээ авдаг. Тэгтэл энэхүү байдал бусад дүүргээс ирж байгаа, ойролцоох хороодоос ирж байгаа харилцагчид төдийлөн хүрч чадаагүй байна. Тиймээс орон зайн хувьд тооцоолж шинээр салбар нээж, боломжит газруудад хаан банкны

үйлчилгээг ойртуулж өгөх нь ачааллыг бууруулах боломжтой юм. Анкетын судалгаанд БЗД, СХД-ын харилцагч нар дийлэнх хувийг эзэлж байгаа нь тухайн нутаг дэвсгэрт банкны үйлчилгээ дутмаг байгаа нь ажиглагдаж байна. Хаан банкны одоогын салбарын байршлыг үзвэл Хотын төв болох бизнесийн бүс рүү төвлөрсөн зарим тохиолдолд банкны салбар хоорондын зайг 100м-200м байршуулсан байна. Анкетын судалгааны тусламжтай цаашид зах зээлд хүрч ажиллахыг үзүүлсэн.




Зураг 9. Хаан банкны салбар нээх боломжит байршлууд
(Эх сурвалж: Зохиогч)

Арилжааны банкуудын шинэ салбарын орон зайн төлөв

Хаан банкны шинээр нээх боломжтой байршил, Голомт банкны шинээр нээх боломжтой байршлуудыг давхцуулбал тухайн хоёр банк хамгийн түрүүнд нээвэл зохистой байршил буюу банкны зах зээлийг эзлэн харилцагч нараа татаж өөрсдийн үйл ажиллагааг өргөжүүлэх боломжтой юм. Түүнчлэн хуучин харилцагч нараа өөр банканд алдах эрсдэлийг бууруулах бөгөөд харилцагч нарыг татах гол байршил юм. Эдгээр байршлуудыг авч үзвэл: БЗД-ийн 16-р хороо,

Шар хад, Ботаник, Шөнийн дэлгүүр гэж нэрлэгдсэн байршлуудад юм. Сүхбаатар дүүрэгт 13-р хороод, ЧД-т 10-р хороо буюу Их тойрог, 7-р хороо хуучнаар Зурагтын эцэст, БГД-ийн 5-р хороо буюу 25-р эмийн сангийн уулзвар, СХД-ийн 27-р хороо, 7-р хороо, 28-р хороо, 11-р хороодод байршлуудад арилжааны банкуудын салбар нэгжийг нээвэл илүү үр ашигтай ажиллана. Түрүүлж салбараа нээсэн нь харилцагч нарыг татах боломжтой бөгөөд тухайн нутаг дэвсгэрт банкны салбар нэгжгүй байна.



Зураг 10. Хаан банк, Голомт банкны шинээр салбар нээх боломжит байршуулалд давхцсан байдал
(Эх сурвалж: Зохиогч)

Судалгааны ач холбогдол

Энэхүү судалгаа нь олон улсад хэрэглэгддэг орон зайн загварчлалыг манай улсад суурьшуулах аргачлалыг гаргаж ирсэн бөгөөд банкны ачаалал болон орон зайн хувьд тооцоололт хийсэн. Арилжааны банкны хэтийн төлөвийг гаргаснаар тухайн салбарт учирч болохуйц хохирлыг тооцоолж болох бөгөөд үүнд хүн амын өсөлт, хороодын тэлэлт, үйлдвэрлэл үйлчилгээний газрууд, гэх зэргээр орон зайн загварчлал ашиглах нь нэн тэргүүний ажил юм. Энэхүү судалгаа нь “Банкны зах зээлд орон зайн шинжилгээ хийх аргазүй” судалгаа нь дээр үндэслэгдсэн бөгөөд цаашдын хэтийн төлөвийг тодорхойлж болох юм.

Орон зайн загварчлал нь банкны зах зээлийг илүү бодитоор дүрслэх аргачлал болох учир тухайн нутагт дэвсгэр тухайн банкны зах

зээлийн эзлэх байдал, харилцагчдыг татах банкны маркетингийн ажил, банкуудын өрсөлдөөн гэх зэргийг тооцоолох боломжтой болсон байна. Энэхүү загварчлал нь банкны салбарын байршил, түүнийг үнэлэх, АТМ байршуулах газрыг зөв оновчтой тогтоох, хэрэглэгчийн зах зээл, маркетинг, нийгэм эдийн засгийн төлөв байдлын судалгааг илүү нарийн төвшинд хийх боломжтой. Банк өөрөө хүсвэл өөрийн орон зайн мэдээллийн сангийн үндсэн суурь санг бүрдүүлэх. Зах зээлийн өрсөлдөөний тооцооллуудыг орон зайн хувьд гаргах БИГ ДАТА буюу байгууллагын мэдээллийн санг орон зайн мэдээлэлтэй хослуулан ашиглах зэргээр орон зайн шинжилгээ хийх боломжтой юм. Орон зайн шинжилгээ нь олон улсад хэрэглэдэг бөгөөд тухайн байгууллагын үйл ажиллагааг дэмжих байдлаар ашиглагддаг.

Дүгнэлт

Энэхүү судалгааг хийснээр Улаанбаатар хотын арилжааны банкны зах зээлийн орон зайн шинжилгээг хийх банкны зах зээлийг тодорхойлох арга зүйг гаргаж ирсэн болно. Аргазүйн тусламжтай салбарын ачааллыг тооцоолж, ачааллыг бууруулах боломжит хувилбарыг гаргасан. Тус аргазүйг анкетын судалгааг арилжааны банкнууд болох Хаанбанк, Голомт банкнуудын 12 салбар нэгжээс 450 харилцагч нараас судалгаа авч боловсруулалт хийсэн. Улаанбаатар хотын хүн ам, харилцагч хоёрын хамаарлын шинжилгээ $R=0,98$ буюу хүчтэй хамааралтай байгаа бөгөөд цаашид банкны зах зээлийг тооцоолох үндсэн үзүүлэлт юм. Орон зайн зах зээлийг тооцоолох голлох хүчин зүйлс нь барилгажсан талбай, зам тээврийн сүлжээ, хотын хүн ам, харилцагч нарын байршил зэргийг авч үзсэн. Судалгааны дүнгээс үзэхэд Голомт банк, Хаан банкны хувьд харилцагчдын алслагдсан байдал, хүн амын нягтшил зэргийг харгалзан нэн тэргүүнд Баянзүрх дүүрэг, Сонгино-Хайрхан дүүргүүдийн сонгогдсон хороодод шинээр салбар нээж ажиллуулах боломжтой байна. Шинээр салбар байгуулахдаа томоохон худалдааны төвүүд, хүн амын зорчих урсгал зэрэг нөхцөлүүдийг харгалзаж үзэх хэрэгтэй. Энэ судалгааны ажлаар банкны салбаруудын ачааллыг тооцоолж цаашдын орон зайн хэтийн төлөвлөгөөг гаргахыг зорьсон. Зорилгынхоо хүрээнд тухайн орон зайн бүсийн ямар байршлуудад банкны салбар хүрэлцээтэй ажиллаж байна мөн ямар хэсэгт ачаалал ихтэй байгааг зураглан боловсруулсан. Мөн түүнчлэн дүүрэг хоорондын шилжих хөдөлгөөнийг тооцоолж, харилцагч нарын мэдээллийн санг үүсгэж банкны эрсдэлийг тооцоолох боломжтой болохыг гаргаж ирсэн. Орон зайн тооцооллын аргачлалыг үзүүлэхдээ цацраг хэлбэрээр үзүүлсэн бөгөөд тухайн харилцагч банк хоорондын алслагдсан зайг гаргасан нь банкны үйлчилгээнээс алслагдсан орон зайг үзүүлсэн. Арилжааны банкнуудын ерөнхий чиг хандлага үйлчилгээний байгууллага руу чиглэсэн байна.

Банкны салбарт уламжлалт аргаар хүснэгт, асуулга, статистик мэдээг ашиглан бодлого боловсруулдаг бол орон зайн дүн шинжилгээ хийснээр илүү бодитой, хэрэгжүүлж болохуйц үр дүн гаргаж цаашдын үйл ажиллагаанд тулгуур болохуйц бизнес төлөвлөлт хийж болох юм. Түүнчлэн дараа дараагийн судалгаагаар энэхүү арга зүйг илүү нарийвчлан судлах боломжтой бөгөөд цаашид энэ судалгааг үндэслэн банкны маркетингийн судалгаа, бизнес төлөвлөлтийн судалгаа хийх боломжтой юм.

Номзүй

- Ana Maria C., Luciene D., 2010, "Spatial Decision Support System for Bank-Industry Based on GIS and Expert Systems Integration" [Цахим] Хамгийн сүүлд үзсэн огноо 2015.04.05 <http://www.intechopen.com/>.
- Eliot H., MacDonald., 2001, "GIS in Banking: Evaluation of Canadian Bank Mergers" [Цахим] Хамгийн сүүлд үзсэн огноо 2015.04.10 <http://www.cjrs-rcsr.org/>.
- Gabriela D., Laurentiu D., Simona M., 2010, "Geographical Informational Systems - Applicability in Investments and Banking", [Цахим] Хамгийн сүүлд үзсэн огноо 2015.04.20 <http://feaa.ucv.ro/>.
- Монгол улсын үндэсний статистикийн хороо., 2015, [Цахим] Хамгийн сүүлд үзсэн огноо 2015.02.28 <http://www.nso.mn/monpopnotes.html>.
- Монголын банкны холбоо., 2015, [Цахим] Хамгийн сүүлд үзсэн огноо 2015.03.15 <http://mba.mn/>.
- Колин Робсон., 2006, "Бодит ертөнцийг судлахуй. Нийгмийн ухаан болон мэргэжлийн судлаачдад зориусан гарын авлага", Улаанбаатар.Сансудай хэвлэх үйлдвэр.
- Балж Г ба Мөнхдулам Д., 2006, "Банк санхүүгийн үндэс". Улаанбаатар.МУИС хэвлэх үйлдвэр.
- Pattison WD., (1990). "Four Traditions of Geography" Journal of Geography: pp. 202-6. Reprint of a 1964 article.

ТӨВИЙН БҮСИЙН ДОТООД БҮСЧЛЭЛИЙГ ШИНЭЧЛЭН ТОГТООСОН АСУУДАЛ

Ц.Базарханд¹, Б.Чинбат¹, П.Мягмарцэрэн¹

¹Монгол Улсын Их сургууль, Шинжлэх Ухааны Сургууль, Газарзүйн тэнхим, Улаанбаатар хот, Монгол Улс

ЭШӨ-ийн цаглабар:

Хүлээн авсан огноо: 23/11/2016

Хэвлэхийг зөвшөөрсөн огноо:

23/01/2017

Түлхүүр үгс: Бүс нутаг, Төв хязгаар загвар, Дэд бүс, Бичил бүс, Дотоод бүсчлэл

Keywords: *Regional area, sub-region, central-limit model, micro-zoning, inner-zoning*

Зохиогчтой холбогдох цахим шуудан:

bazarkhand_ts@num.edu.mn

Үндэслэл

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар Баруун, Хангайн, Төвийн, Зүүн, Улаанбаатар гэсэн үндсэн бүсүүдийг тогтоож бүсийн төв ба тулгуур хотуудыг тогтоосон байдаг. Бүс нутгийг авч үзэхдээ Орчин үеийн судлаачдаас Х.Хервиг, А.Г.Гранберг, Л.Шагцел нарын бүс нутгийн талаарх тодорхойлолтыг авч үзье. Гранберг (2001) "Бүс нутаг нь хоорондоо харилцан уялдаатай нэгжүүдээс бүрддэг нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг юм", Степанова (2000). "Бүс нутаг нь эдийн засгийн үйл ажиллагаанууд, байршил хоорондын бараа, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн урсгал, бүс хоорондын харилцааны үр нөлөө гэсэн 3 элементээс бүрддэг нээлттэй систем", Гранберг (2000). "Бүс нутаг нь байгаль орчин, газарзүй, нийгэм,

ХУРААНГУЙ

Бүс нутгийн дотоод бүсийг тэнхлэгт -төв хязгаарын загварыг дэвшүүлж, дээрх загвараар тодорхойлсон болно. Дэд бүс тус бүрт үйлдвэрлэл аж ахуйн төрөлжилт бүхий бичил бүсчлэл тогтоох санал дэвшүүлж байна. Төвийн бүсийн дотоод бүсүүдийг тогтоохдоо байгалийн нөхцөл, нөөц, орон зайн хамаарлыг чухалчлан авч үзээд бүсийн хөгжлийн хөгжлийн хөтөлбөрт дурдагдсан хөгжлийн чиг хандлагыг харгалзсан болно. Бүсийн дотоод бүсчлэлийг тогтоохдоо нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, нутагшил, суурьшил, нөөц, төвийн чиг үүрэг, хөдөө аж ахуйн бүсчлэл зэргийг харгалзсан. Дэд бүсүүдэд аж үйлдвэр, эдийн засгийг төрөлжүүлэн хөгжүүлэх чиг үүргүүдийг тогтоосон. Төвийн бүсийн нутаг дэвсгэрийн тогтолцоо нь 3 дэд бүс, 16 бичил бүстэй бөгөөд тодорхой эрэмбэ бүхий төв суурингуудыг багтаасан болохыг тодорхойллоо. Төвийн бүсэд дэд бүс, бичил бүсүүдийг бүлэг суурингийн тогтолцоо, аж ахуй нутаг дэвсгэрийн кластерийн чиг хандлагад тулгуурлан хөгжүүлэх боломжтой болохыг харуулж байна. Бичил бүс тогтоосноор оронзайн зохион байгуулалт хийхэд нутаг дэвсгэрийн онцлог ялгаа, байгаль, аж ахуйн нөхцөл нөөц, хот суурингийн чиг үүрэг зэргийг төлөвлөлтөнд харгалзах боломжийг нэмэгдүүлэхээс гадна бичил бүс бүлэг сууринг тодорхой чиг үүрэгтэйгээр төлөвлөн хөгжүүлэх боломжтой болно.


ABSTRACT

For determining the zoning of regional area, sub-regions and local areas we used a central-limit model in central axis. Based on analyses of socio-economic situation and habitat, settlements, also resources and agricultural divisions in determining an inner zoning of the central region. Recommending a micro-zoning of industrial economic diversification for each sub-region. To establish micro-regions will improving opportunity of keeping territorial distinction, environmental and economic conditions resources and municipal functions in spatial organization in planning and also will be able to develop by specific functions zone areas. Considering the territorial system of the central region of 3 sub-regions and 16 micro-regions considered include the role of cities in particular order centre functions. Division of central area in sub-zones and sub-zones with micro-region, a group of urban systems that is effective for planning, regional development and also its valid for planning production and service clusters in micro-regions and groups.

эдийн эдийн засаг, улс төрийн хүчин зүйлсийн нөлөөллөөр бий болдог хил хязгаар нь улсын хил шиг хатуу тогтоогдсон биш цаг хугацааны явцад өөрчлөгдөж болдогоороо онцлогтой байна" хэмээн тус тус тодорхойлсон.

Бүсчлэлийг хэтэрхий ерөнхийлсөн дотоод бүсчлэлийн асуудлыг хөндөөгүй нь байгаль нийгэм нийгэм эдийн засгийн онцлог нөхцөлүүдийг нарийвчлэн үзэх аргагүйд хүргэж байна. Дан ганц тэнхлэгийн эсвэл төв, хязгаарын чиг хандлагад тулгуурлан бүс нутгийн хөгжлийн эдийн засгийн газарзүйн чиг баримжааг тодорхойлох нь хангалтгүй. Тиймээс Кругманы дэвшүүлсэн төв-хязгаар, Д.Базаргүр нарын Бүс нутгийг тэнхлэгээр хөгжүүлэх үзэл баримтлал мөн судлаач Л.Наранцэцэгийн цөм-төв- бүсийн хандлага зэргийг харгалзан үзээд бүс нутгийн хөгжлийн эдийн засгийн газар зүйн шинэ хандлагад хамаарах бүс нутаг

төлөвлөлтийн аналогийн загварыг дэвшүүлж байна.



Зураг 1. Тэнхлэгт төв-хязгаарын загвар

Эх сурвалж: (Базарханд 2015)

Онолын хувьд дэвшүүлж буй үзэл баримтлал

2001 онд Улсын их хурлаар баталсан Монгол улсын "Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал"-аар Баруун, Хангайн, Төвийн Зүүн, Улаанбаатарын гэсэн үндсэн бүсүүдийг тогтоож бүсийн төв ба тулгуур хотуудыг тогтоосноос дотоод бүсчлэлийн асуудлыг хөндөөгүй нь хэтэрхий ерөнхийлсөн байгаль нийгэм эдийн засгийн онцлог нөхцөлүүдийг нарийвчлан үзэх аргагүйд хүргэсэн (Галбадрах, 2006). Мөн бүс бүрт чиг үүрэг тогтоосон дотоод бүс байхгүйгээс бүсэд хамрагдаж буй хот суурин газруудын улс ба бүсийн түвшинд гүйцэтгэх

чиг үүрийг тодорхойлоогүй, хот суурин газруудын таталцал нөлөөлөлд тулгуурласан бүлэг суурингийн тогтолцоог бүсийн хөгжлийн төлөвлөлтөнд тогтоож өгөөгүй зэргээс хамааралтай гэж үзэж байна. Төвийн бүсэд Говь-Сүмбэр, Дархан-Уул, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Сэлэнгэ, Төв аймгуудыг хамруулж тулгуур төвөөр Дархан, Зуунмод хотыг тус тус тодорхойлжээ. Нийслэлийн нутаг дэвсгэрийг Улаанбаатарын бүс болгож нийслэл хот, түүний дүүргүүдийн нутаг дэвсгэр, хот орчмын бүсийн дагуул хотууд орохоор тодорхойлсон байна.




Зураг 2. Монгол улсын эдийн засгийн мужууд /2001 он/

Бидний дэвшүүлж буй тэнхлэгт төв - хязгаарын загварт Эдийн засгийн бүс нь дотоод буюу дэд бүстэй байх бөгөөд төв бүс, хязгаар бүсүүдэд мезо түвшинд хуваагдана. Бүс бүр бүлэг суурингийн тогтолцоотой байх бөгөөд гол тэнхлэгийн дагуу орших суурин газар нь бүсийн аль нэг эрэмбийн төвүүд байна. Өөрөөр хэлбэл дэд бүс бүр нь бүсийн төвтэй байх ба төв, дэд бүсийн төв болох суурин газар нь эдийн засгийн бүсийн төв болж бусад бүс, дэд бүс, суурин газруудыг холбосон тэнхлэгийн дагуу байрших нь зүйтэй. Шинээр дэвшүүлж буй аналогийн загвар нь тэнхлэг, төв, хязгаар гэх үндсэн 3 хүчин зүйлийг харгалзсаны зэрэгцээ макро, мезо түвшиний бүсчлэлийг авч үзсэн цаашид микро бүсүүдийг тогтоон хөгжүүлэх боломжийг олгоно гэж үзэж байна.

Төвийн бүсийн нийгэм эдийн засгийн өнөөгийн байдал.

Төв бүс нь засаг захиргааны нэгжийн хувьд 7 аймаг, 95 сум, 359 багт хуваагдаж байна (“Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” Монгол улсын 2001 оны 57 дугаар тогтоолын хавсралт, Улаанбаатар.2001). Тус бүс

нь газарзүйн байршлын хувьд уртрагийн дагуу сунаж тогтсон, Евро Азийг холбосон гол тэнхлэг тус бүсээр дайран өнгөрдөг, бүсийн гол төв хотууд нь энэ тэнхлэгийн дагуу байршиж байгаа нь бусад хот суурингуудаас байршлын хувьд давуу талтай. Өөрөөр хэлбэл Монгол улсын зам, тээвэр дэд бүтцийн хамгийн ашигтай байрлалд орших ба гадаад болон дотооддоо авто зам, төмөр замаар шууд харилцах боломжтой. Төвийн бүс нь манай улсын нутаг дэвсгэрийн 30.3% буюу нийт 470 гаруй мян (473.6мян) ам км нутагтай. Дунджаар далайн түвшнээс дээш 800-1500 м өндөрт байрладаг. Баруун талаар Хангайн нуруу, зүүн хойд талаараа Хэнтийн хил залган оршино. Өмнөд талыг нь Говь цөл эзэлдэг. Энэ нь бусад эдийн засгийн бүсүүдээс байгалийн орчин нөхцлийн хувьд эрс тэс ялгаатай байдгаараа онцлогтой. Энэ бүсэд Орхон-Сэлэнгийн бэлчир, Бага Хэнтийн уулсаас урагш улсын хил хүртэлх ойт хээр, тал хээр, говь, цөлийн бүсийн тэгшивтэр гадарга зонхилох бол бүсийн хойд хэсэг нь гадаргын усан сүлжээ сайтай, ой модны багагүй.



Зураг 3. Төвийн бүсийн засаг захиргааны хуваарилалт

Эх сурвалж: (Ц.Базарханд 2015)

Төвийн бүсийн нутаг дэвсгэрийн 80.3 хувийг хөдөө аж ахуйн газар, 11.1 хувийг ойн

сангийн газар, 0.2 хувийг усан сан бүхий газар, 0.2 хувийг хот, суурин, үйлдвэр уурхайн газар,


0.2 хувийг зам, шугам сүлжээний газар, 8.0 хувийг нөөц болон ашиглах боломжгүй газар тус тус эзэлж байна.

Энэ бүсэд нийт 27 орчим сумыг хамарсан 6671.9 мян.га газрыг эзэлсэн тусгай хамгаалалттай газар нутаг 12 байгаа нь улсын нийт тусгай хамгаалалттай газар нутгийн 31.8 хувийг эзэлж байна. Тусгай хамгаалалттай газар нутгууд нь хүн ам төвлөрсөн болон цаашид төвлөрөн хөгжих газруудтай байршлын хувьд ойр байгаа нь хамгаалалт, менежментийн цогцолбор үйл ажиллагааг илүүтэй шаардахаас гадна шинээр бүрэлдэн бий болох болон одоо байгаа дэд бүтцийн сүлжээг ашиглан аялал жуулчлалыг зохистойгоор хөгжүүлэх боломжийг олгоно (Цэдэндамба, 2011).

Хүн ам нутагшил, суурьшил. Төвийн бүсийн хүн амын суурьшлыг авч үзвэл, хотжилт хамгийн өндөр бүс буюу зөвхөн Улаанбаатар хотын дараа орно.

Сүүлийн жилүүдэд төвийн бүсийн хүн амын цэвэр өсөлт харьцангуй нэмэгдсэн бөгөөд цаашид ч үргэлжлэх төлөвтэй байна (Давааням ба Бямбаа, 2001). Төвийн бүсийн 1000 хүнд

ногдох ердийн цэвэр өсөлт 2006 онд 24.6% байсан бол 2014 онд 43.8% болж 19.2% хувиар нэмэгджээ. Төвийн бүсэд 2014 оны байдлаар 475,899 мянган хүн буюу манай улсын нийт хүн амын (2,937,927 мянга) 16 хувь нь оршин сууж байна. Хүн амын цэвэр өсөлт нэмэгдэж байгаа ч шилжин явагчийн тоогоор Төвийн бүс улсын хэмжээнд Баруун бүсийн дараа, харин шилжин ирэгсдийн тоогоор Улаанбаатар хотын дараа орж байгаа нь энэ бүсэд шилжих хөдөлгөөн эрчимтэй явагдаж байгааг харуулж байна. Төвийн бүсэд хүн амын дундаж нягтшил 1.1 байгаа бөгөөд улсын дундажаас 0.72-оор бага байгаа юм. Төвийн бүсийн хувьд 2000 он хүртэл хүн ам харьцангуй тогтвортой өсч байсан бол 2005 онд 3% -иар буурч, 2014 оны байдлаар 7%-аар өссөн үзүүлэлттэй байна. Төвийн бүсэд хүн амын нягтшилын хувьд дотоод ялгаа ихтэй. Тухайлбал Төв, Сэлэнгэ, Дархан, Говьсүмбэр аймгуудад энэ үзүүлэлт нь улсын дундажаас ойролцоогоор 2 дахин илүү байхад Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудад улсын дундажаас 3 дахин бага байна (УИХ, 2003).



Зураг 4. Төвийн бүсийн хүн амын нягтшил

Эх сурвалж: (Ц.Базарханд 2015)

Нягтшилтыг сумдаар авч үзвэл нэгж км.кв-д Даланзадгад 808, Сүхбаатар 488, Зуунмод 791, Шарын гол 85, Дархан 711, Замын үүд 31 хүн байгаа нь харьцангуй өндөр нягтшилтай байгаа бол Мөнгөнморьт, Эрдэнэ, Баяндэлгэр, Баян-Өнжүүл, Сэргэлэн, Цагаандэлгэр, Баянцагаан,

Дэлгэрэх, Айраг, Алтанширээ, Баянжаргалан, Өндөршил, Өргөн, Гурвансайхан, Хулд, Дэлгэрхангай, Өлзийт, Сайхандулаан, Мандал-Овоо, Эрдэнэ, Мандах, Булган, Улаанбадрах, Цогт-Овоо, Манлай, Гурвантэс, Ханхонгор, Сэрвэй, Хөвсгөл, Баяндалай, Хатанбулаг,

Ханбогд, Баян овоо, Хүрмэн, Ноён, Номгон зэрэг сумдад хамгийн харьцангуй доогуур байна (Батцэнгэл ба бусад 2012). Бүсийн дотоодод хүн амын нягтшилын зөрүү их байгаад хот, хөдөөд болон бусад суурин газруудад ч хоорондын хөгжлийн ялгаа ихээр

хадгалагдаж байгаа нь нөлөөлдөг. Мөн хүн амын шилжих хөдөлгөөнийг авч үзвэл нягтшил багатай алслагдмал бүс нутаг, хөдөөгийн суурингаас хүн амын нягтшил өндөртэй хот, хот орчмын суурингууд руу шилжих, шилжилт хөдөлгөөн давхар нөлөөлж байгаа юм.

Хүснэгт 1. Хүн амын нягтшил

	Аймгууд	Сум, дүүргийн тоо	Баг, хорооны тоо	Хүн ам	Газар нутаг ам км	Нягтшил
1	Сэлэнгэ	17	56	106212	41153	2,58
2	Төв	27	97	90107	74041	1,21
3	Дархан	4	24	99947	3275	30,5
4	Говь-Сүмбэр	3	10	16058	5542	2,89
5	Дундговь	15	64	44351	14176	3,12
6	Дорноговь	14	57	63808	109472	0,58
7	Өмнөговь	15	54	59694	165450	0,36
8	Нийт	95	362	480177	413107	1,16
9	Улсын	340	1662	2995949	1564100	1,91
10	Эзлэх хувь	27,94%	21,78%	16,00%	26,41%	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүн амын шилжилт хөдөлгөөнийг авч үзэхдээ: "Хүн амын шилжих хөдөлгөөн гэдэг нь хүмүүсийн байнгын оршин суух газраа сольж, нутаг дэвсгэрийн хувьд нэг нутгаас нөгөө нутагт шилжин суух үзэгдэл юм" (Баянтер, Сүхбаатар ба бусад 1971). Энэ нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хүн амын тоо, бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлтөнд голлон нөлөөлдөг хүчин зүйл юм. Монгол улсад сүүлийн 20 гаруй жилд хүн амын дотоод, гадаад шилжих хөдөлгөөн эрчимжиж, аймаг, нийслэл, бүс нутгийн хүн амын тоо, бүтэцд ихээхэн өөрчлөлт гарсан төдийгүй нийгэм, эдийн засгийн хөгжилд хүчтэй нөлөөлж байна (Батцэнгэл ба бусад 2012).

Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшилын хот, хөдөө гэсэн үндсэн 2 хэлбэртэй бөгөөд хүн амын шилжих хөдөлгөөний нөлөөгөөр хотжилт эрчимтэй

явагдаж 2014 оны байдлаар 63 хувьд хүрчээ. Төвийн бүсийн хувьд 45 хувь нь хот суурин газарт амьдарч байна. 1990 оноос 2000 он хүртэл хотжилт 4.4%-аар өссөн бол 2000 оноос 2014 оны хооронд 2.8% -иар өсч, Төвийн бүс нь хотжилтын түвшингээрээ Зүүн бүсээс 3%-иар, Хангайн бүсээс 7%-иар, Баруун бүсээс 12% илүүтэй байна. Сумын төвүүдийн хүн амын тоог авч үзвэл хөдөөгийн суурингийн тоо болон хот маягийн суурингийн тоо тогтвортой, хотын тоо өсөлтэй байна. Аймгийн төв болон томоохон үйлдвэрлэл, уул, уурхайн сууринд ихээр татагдаж байгааг харуулж байна (Батцэнгэл ба бусад 2012). Хот суурингийн хүн амын тоо өсөх нь улс, бүсийн хэмжээнд хотуудын хэлбэр тоонд байнга өөрчлөлт орж байгаагаас тодорхой харагдана.

Хүснэгт 2. Хот суурингийн тоо, хүн ам

Хэлбэр	Сумын төвийн хүн	1990	1995	2000	2005	2014
Хөдөөгийн суурин	500-1500	55	57	59	62	59
Хот маягийн суурин	1501-5000	29	27	23	22	24
	5001-10000	4	6	6	4	4
Хот	10001-дээш	7	5	7	7	7


	Нийт сумын	95	95	95	95	95
--	------------	----	----	----	----	----

Эх сурвалж: Статистикийн эмхтгэл, Үндэсний статистикийн хороо

Бүлэг суурин. Хэдийгээр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд дотоод бүсүүдийг ялгаагүй ч 2000 онд тодотгон гүйцэтгэсэн “Хүн амын нутагшилт, суурьшилт, бүсчилсэн хөгжлийн ерөнхий төсөл”-д Монгол улсын хүн амын нутагшилт, суурьшлын тогтолцооны схемийг боловсруулахад бүлэг суурингийн тогтолцоог

тодорхойлсон нь үндсэндээ бүсийн дотоод бүсчиллийг тогтоох боломжтойг харуулсан. Үүнд төвийн бүсийн хүн амын нутагшилт, суурьшилын тогтолцоог доорх байдалтай авч үзжээ (Нийслэлийн зураг төслийн хүрээлэн, 2013).

ЭДИЙН ЗАСГИЙН ТӨВИЙН БҮСИЙН НУТАГШИЛ СУУРЬШЛЫН ТОГТОЛЦОО



Зураг 5. Эдийн засгийн төвийн бүсийн нутагшил, суурьшлын тогтолцоо

Эх сурвалж: "Хүн амын нутагшилт, суурьшилт, бүсчилсэн хөгжлийн ерөнхий төсөл" 2000 он.

Энэ зургаас хархад нийслэл Улаанбаатар хот руу чиглэсэн таталцлын нэг үндсэн чиглэл байгаа бол засаг захиргааны үүрэг давамгайлсан аймгийн төв, сумын төв, үйлчилгээний үүрэг бүхий суурингууд руу чиглэсэн хоёрдахь үндсэн чиглэл байна. Нийслэлийн эрчимтэй таталцал нөлөөллийн бүс буюу Төв аймгийн бүх сумдыг Улаанбаатар хот руу шууд татагдах

чиглэлтэйгээр авч үзсэн (Пүрэвцэрэн, 2001). Энэ нь Нийслэлийн эрчимтэй таталцал нөлөөллийн бүсийг Төв аймгийн хилээр тогтоож болох боломжтойг харуулсан боловч тус бүсэд бичил бүс, бүлэг суурингийн тогтолцоонууд үүсч болохыг тусгаагүй орхисон. Хот суурин газрууд нь орон зайд тодорхой эрэмбэтэй төвийн үүрэг гүйцэтгэж

байгаа учир ойр орших, дээд эрэмбийн төв рүүгээ татагдах онолын дагуу бүлэг суурингийн тогтолцоонуудад хуваагдана. Бүлэг суурингийн тогтолцоо нь дэд бүс, бичил бүсийг тогтоох нэг үндэслэл болно. Бүлэг суурингийн тогтолцоог тодорхойлохын тулд төв суурин газруудын

эрэмбийг нэн тэргүүнд авч үзэх шаардлагатай. Хот суурингийн чиг үүрэг өндөрсөх тусам төвийн эрэмбэ дээшлэх хандлагыг авч үзээд төв бүсийн хот суурингийн төвийн эрэмбийг доорх байдалтай авч үзлээ.

Хүснэгт 3. Төв бүсийн хот суурингийн эрэмбэ

Эрэмбийн дэс дугаар	Хот суурингийн нэр	Хот суурингийн чиг үүрэг
Нэгдүгээр эрэмбийн төв	Улаанбаатар	Олон үүрэг бүхий нийслэл
Хоёрдугаар эрэмбийн төв	Дархан	Засаг захиргаа үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан улсын зэрэглэлтэй хот
Гуравдугаар эрэмбийн төвүүд	Сүхбаатар	Засаг захиргааны үйлчилгээний үүрэг давамгайлсан хот
	Зуунмод	Засаг захиргааны үүрэг давамгайлсан хот
	Мандалговь	Засаг захиргааны үйлчилгээний үүрэг давамгайлсан хот
	Даланзадгад	Засаг захиргааны үйлчилгээний үүрэг давамгайлсан хот
	Сайншанд	Засаг захиргааны үйлчилгээний үүрэг давамгайлсан хот
	Чойр	Үйлчилгээний засаг захиргааны үүрэг давамгайлсан хот
Дөрөвдүгээр эрэмбийн төвд бүлэг суурингийн төвийн үүрэг бүхий сумын төвүүд хамарна.		

Нэгдүгээр эрэмбийн төв нь олон үүрэг бүхий нийслэл хот Улаанбаатар бол харин хоёрдугаар эрэмбийн төв нь засаг, захиргаа, үйлдвэрлэл, үйлчилгээ давамгайлсан улсын зэрэглэлтэй хот Дархан болно. Энэ 2 хот нь төв бүсийн төдийгүй улс орны гол том хот, төв бүс нутгийг бүрдүүлэгч үндсэн төв болж өгч байна.

Гуравдугаар эрэмбийн төвүүдэд бусад аймгийн төвүүд болох Сүхбаатар, Зуунмод, Мандалговь, Даланзадгад, Сайншанд, Чойр хотууд орж байна. Төв бүсийн бүлэг суурингийн тогтолцоог дээд эрэмбийн төв рүү татагдах чиглэх, дэд бүтцийн гол тэнхлэгүүд, харгалзан шинэчлэн тогтоолоо.

Хүснэгт 4. Төв бүсийн бүлэг суурингийн тогтолцоо

Бүлэг суурингийн төв нь Дархан хот, Дархан-уул аймаг бүхэлдээ, Сэлэнгэ аймгийн Орхон, Сант, Орхонтуул, Сайхан, Хушаат, Жавхлант, Ерөө, Хүдэр сумд
Бүлэг суурингийн төв нь Сүхбаатар хот, Түшиг, Зүүнбүрэн, Шаамар, Алтанбулаг Алтанбулагийн олон улсын чөлөөт худалдааны бүс
Мандал, Баянгол сумд
Улаанбаатар хот түүнд шууд татагдаж буй Төв аймгийн Алтанбулаг, Зуунмод, Батсүмбэр, Сэргэлэн, Эрдэнэ, Баян-Өнжүүл сумд
Аргалант төвт бүлэг сууринд Аргалант, Цээл, Баянцогт, Угтаалцайдам, Заамар, Баянхангай, Баянчандмань төвт бүлэг сууринд Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр сумд
Төв аймгийн Эрдэнэ Мөнгөнморьт сумд, бичил бүсийн төв нь Эрдэнэ сумын төв
Лүн төвт бүлэг сууринд Лүн, Эрдэнэсант, Өндөрширээт, Бүрэн, Дэлгэрхаан сумд
Багануур төвт бүлэг сууринд Багануур хот, Баяндэлгэр, Баянжаргалан, Мөнгөнморьт сумд. Багахангай төвт бүлэг сууринд Багахангай дүүрэг, Баян, Архуст, Баянцагаан сумд
Бүлэг суурингийн төв нь Мандалговь, хамрагдах сумд нь Сайхан-овоо, Дэлгэрхангай, Хулд, Луус, Эрдэнэдалай, Адаацаг, Дэрэн, Дэлгэрцогт, Гурвансайхан, Өлзийт

Бүлэг суурингийн төв нь Сайншанд, Иххэт, Алтанширээ, Дэлгэрэх, Сайхан дулаан, Өргөн, Эрдэнэ, Улаанбадрах, Замын-үүд, Зүүнбаян сумд Замын-Үүдийн олон усын чөлөөт худалдааны бүс
Бүлэг суурингийн төв нь шинээр үүсэх Оюутолгой тосгон, Ханбогд, Баян-овоо сумд, Гашуунсухайт боомтын хамт
Бүлэг суурингийн төв нь Даланзадгад, Номгон, Хүрмэн, Баяндалай, Булган, Ханхонгор, Мандал-овоо, Цогт-овоо
Бүлэг суурингийн төв нь Чойр, Говьсүмбэр аймгийн Шивээ-овоо, Баянтал сумд, Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-угтаал, Баянжаргалан, Өндөршил, Дорноговь аймгийн Даланжаргалан сумд
Бүлэг суурингийн төв нь шинээр үүсэх Цагаансуварга уурхайн суурин, Дорноговь аймгийн Мандах, Хөвсгөл, Хатанбулаг сумд, Хангимандал боомтын хамт
Цогтцэций бүлэг суурингийн төвтэй. Шинээр үүсэх уурхайн тосгон, Манлай сумын хамт
Бүлэг суурингийн төв нь Гурвантэс сум, Ноён, Сэврэй сумд, Шивээхүрэнгийн боомтын хамт.

Эх сурвалж: (Базарханд 2015)


Тэнхлэг. Төвийн бүс нь бусад бүсүүдтэй харьцуулбал зам тээвэр, харилцаа холбоо сайн хөгжсөн. Тус бүсэд төмөр замын урт 1374 км, хатуу хучилттай авто замын урт 1495 км, сайжруулсан шороон зам 801 км байна. Хатуу хучилттай зам болон төмөр зам аль нэг дайрч өнгөрдөг 6 аймаг, 28 сум байгаа бөгөөд үлдсэн 67 сум нь сайжруулсан шороон замаар аймгийн төвүүдтэйгээ холбогдсон байна. Төрөл бүрийн замын сүлжээний хангамжийн үнэлгээгээр Төвийн бүсийн Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймаг бусад аймаг, бүс нутгуудтай харьцуулахад нэлээд өндөр байдаг. Энэ нь манай улсын төв хэсэгт орших эдгээр аймгийн нутаг дэвсгэрээр улсын чанартай хатуу хучилттай авто зам болон төмөр замын гол тэнхлэг дайран гардагтай холбоотой. Түүнчлэн төвийн бүс нь замын сүлжээний хангамжийн үзүүлэлтээр Баруун бүсээс 11,8 дахин, Зүүн бүсээс 2,2 дахин, Хангайн бүсээс 1,8 дахин илүү байна (ДБХС, 2000). Гэвч тус бүсийн бусад аймгуудад төрөл бүрийн замын сүлжээг, түүний дотор сайн чанарын авто замын сүлжээг бий болгох шаардлагатай байна. Замын сүлжээний

нягтшил, чанарын үзүүлэлт хангалтгүй байгаа нь бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээний үнэ, өртөг өндөр байх нөхцлийг бий болгодог (Зураг 6).

Зураг 6-аас харахад тухайн бүсийн аймгийн төв хотууд бүгд хатуу хучилттай замаар нийслэл Улаабаатар хоттой холбогдсоноос гадна 23 сумын төвөөс бусад бүх суурин газрууд хатуу хучилттай зам дайран өнгөрдөг эсвэл замаас 50 хүрэхгүй км-ийн зайд оршиж байгаа нь дэд бүтцийн хүрэлцээ хангамж сайтайг харуулж байна. Түүнээс гадна бүсийг дайран өнгөрөх авто болон төмөр замын хосолмол тэнхлэг нь олон үүрэгт тэнхлэгийн үүрэг гүйцэтгэж байна.

Тухайлбал:

1. Бүсийн хэмжээнд: Монгол улсын нийслэл Улаанбаатар хотыг бусад аймгуудын төв, суурингуудтай холбох,
2. Улсын хэмжээнд: Монгол улсыг хойд урд хөрштэй холбох
3. Олон улсын түвшинд: Ази болон Европ тивийг холбох



Зураг 6. Төвийн бүсийн зам тээврийн харилцаа

Эх сурвалж: (Базарханд 2015)

Хүснэгт 5. Төвийн бүсийн зам дагуу хотууд

Хот суурин	Төмөр зам дайрдаг	Хатуу хучилтай зам дайран өнгөрдөг
Аймгийн төв	Сайншанд, Дархан, Сүхбаатар, Чойр	Сүхбаатар, Дархан, Зуунмод, Мандалговь, Даланзадгад, Чойр, Сайншанд
Сумын төв бусад суурин газрууд	Алтанбулаг, Шаамар, Орхон, Шарын гол, Орхон туул, Баянгол, Мандал, Батсүмбэр,, Баян, Баянтал, Сүмбэр, Шивээговь, Даланжаргалан, Айраг, Өргөн, Эрдэнэ, Замын үүд, Орхон	Эрдэнэсант, Лүн, Эрдэнэ, Баяндэлгэр, Баянчандмань. Баянгол, Хонгор, Дархан, Орхон, Шаамар, Орхон(сэлэнгэ), Баруунбүрэн Алтанбулаг, Сайнцагаан, Зуун мод, Сүмбэр, Баянтал, Сүхбаатар, Цогт-овоо, Хулд, Луус, Дэлгэрцогт

Эх сурвалж: (Базарханд 2015)


Бүсийн гол тэнхлэгийн олон үүрэгт байдал нь тэнхлэгийн дагуу орших хот суурингуудын хөгжил, хэтийн чиг хандлаганд эерэг нөлөөтэйгээс гадна дотоод бүсчлэлийг тогтооход онцгой ач холболтой. Дотоод бүсүүдийг тогтоохдоо хот, суурин газруудыг байршлын хувьд хэвтээ болон босоо тэнхлэгийн дагуу оршиж байгаа эсэх, тэнхлэгээс алслагдах зай, нутаг дэвсгэрийн замын сүлжээний нягтрал зэргийг харгалзан үзсэн болно. Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд зам тээврийн сүлжээний нягтралыг авч үзэхдээ авто замын нөлөөллийн хүрээг 50 км, төмөр замын нөлөөллийн хүрээг 70 км-ээр тус тус

авсан болно. Авто замын нөлөөллийн бүсэд Сэлэнгэ аймгийн Хүдэр сумдаас бусад бүх сумд, Дархан аймгийн бүх сумд, Төв аймгийн Бүрэн, Дэлгэрхаан сумдаас бусад бүх сумд, Дундговь аймгийн Адаацаг, Дэлгэрцогт, Дэрэн, Сайнцагаан, Луус, Дэлгэрхангай, Хулд, Өлзийт, Цагаандэлгэр, Баянжаргалан сумд, Говьсүмбэр аймгийн бүх сумд, Өмнөговь аймгийн Гурвантэс, Цогт-Овоо, Цогтцэций, Ханхонгор, Даланзадгад, Баяндалай, Хүрмэн Баян-Овоо, Ханбогд сумд, Дорноговь аймгийн Сайхандулаан, Улаанбадрах, Хөвсгөл, Зүүнбаян, Өргөн, Сайншанд, Эрдэнэ, Алтанширээ, Даланжаргалан, Айраг,

Хатанбулаг сумд тус тус авто замын нөлөөлөлд багтаж байна. Төмөр замын нөлөөллийн хүрээнд Сэлэнгэ, Дархан аймгийн бүх сумд, Төм аймгийн Бүрэн, Дэлгэрхаан сумдаас бусад бүх сумд төмөр замын нөлөөлөлд багтаж байна (Нийслэлийн зураг төслийн хүрээлэн, 2013).

Нөөц. Дотоод бүсийг тогтооход харгалзах нэг үндсэн хүчин зүйл нь бүсийн байгалийн болон нийгмийн нөөцийн зарим хэлбэрүүдийг авч үзсэн. Үүнд уул уурхайн үйлдвэрлэлийн нөөц буюу ашигт малтмал, хүн амын хүнсний болон хөнгөн үйлдвэрлэлийн салбарын гол нөөц болох газар тариалан, мал аж ахуй, үйлдвэрлэлийг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг хөгжүүлэх үндсэн хүчин зүйл хөдөлмөрлөх хүчний нөөц зэргийг харгалзсан (Зураг 7).

Төв бүсийн хөгжлийн хөтөлбөрт төвийн бүсэд ашигт малтмалын судлагдсан орд, илрэл олонтой, нөөц ихтэй, газар зүйн тааламжтай байршилтай учраас ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулан хөгжүүлэх ихээхэн боломжтой гэж үзжээ. Тус хөтөлбөрт тусгагдсанаар бүсийн хэмжээнд нийт 15 төрлийн ашигт малтмалын 645 орд, илэрц байгаагаас 229 нь 11 төрлийн ашигт малтмалын орд, бусад нь илрэлүүд байна. Ашигт малтмалын нөөц нь 7031.0 тонн алт (улсын нийт судлагдсан алтны нөөцийн 86.0%), 1283.9 мян.тн зэс (80.0%), 12,2 тн мөнгө, 162.4 мян.тн холимог металл (4.0%), 420.3 сая тн төмөр (54.0%), 41.4 мян.тн цагаантугалга (87.0%), 17.9 мян.тн гянтболд (11.0%), 43.6 мян.тн молибден (11.2%), 7031 сая тн нүүрс (91.0%), 6.6 сая тн хайлуур жонш (36.0%) болохыг дурджээ.



Зураг 7. Төвийн бүсийн ашигт малтмал, үйлдвэржилт

Эх сурвалж: (Базарханд 2015)

"Тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамааруулах тухай" Монгол Улсын Их Хурлын 2007 оны 27-р тогтоолоор 15 ордуудыг стратегийн ач холбогдолтой гэж үзсэн ба эдгээр стратегийн ордуудаас төвийн бүсэд 8 нь байгаа юм. Үүнд:

1. Таван толгойн Чулуун нүүрсний орд. Өмнөговь аймгийн Цогтцэций суманд байршилтай. Тавантолгой ХХК, Энержиресорс ХХК, Дайцуки ХХК-ийн эзэмшиж байгаа тусгай зөвшөөрлийн хэмжээнд нөөц тооцсон талбайг хамааруулна.

2. Нарийн Сухайтын Нүүрсний орд. Өмнөговь аймгийн Гурвантэс суманд байршилтай. Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан.

3. Багануурын Хүрэн нүүрсний орд. Улаанбаатар хотын Багануур дүүрэгт байршилтай. Нөөц тооцсон талбайг хамааруулна. "Багануур" ХХК олборлодог.

4. Шивээ Овоогийн Хүрэн нүүрсний орд. Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд байршилтай. Нөөц тооцсон талбайг хамааруулна. "Шивээ Овоо" ХХК олборлодог.

5. Төмөртэйн Төмрийн хүдрийн орд. Сэлэнгэ аймгийн Хүдэр суманд байршилтай. Уг ордын тусгай зөвшөөрлийг “БЛТ” ХХК эзэмшиж байсныг 2006 онд цуцалсан. Нөөц тооцсон талбайг хамааруулна.
6. Оюу толгойн Зэс, молибдений орд. Өмнөговь аймгийн Ханбогд суманд байршилтай. Ордын нөөцийн тооцоо бүхий тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцэхэд бэлтгэж байна. Бүлэг ордын хэмжээгээр ойлгоно.
7. Цагаансуваргын Зэс, молибдений орд. Дорноговь аймгийн Мандах суманд байршилтай. Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн бөгөөд хувийн хөрөнгөөр нэмэлт хайгуул хийж байна.
8. Бороогийн Алтны орд. Сэлэнгэ аймгийн Баянгол суманд байршилтай. Монгол Улсын Засгийн газартай тогтвортой байдлын гэрээ байгуулсан.

Цаашид Оюутолгойн зэс, алт, мөнгөний орд, Тавантолгойн коксжих нүүрсний орд, Цагаансуваргын зэс-молибдений орд, Цагаан тугалганы Элстийн бүлэг, Жанчивлангийн бүлэг, Авдрантын бүлэг, Хар-Овоогийн бүлэг, цагаан тугалга-гянт болдын Хар морьтын бүлэг зэрэг шороон ордууд, Сэлэнгэ, Дарханы районд төвлөрч байгаа төмрийн хүдрийн ордууд, Улаан-Овоо, Нарийнсухайт, Гурвантэсийн зэрэг нүүрсний ордуудыг түшиглэн орчин үеийн олборлох, боловсруулах үйлдвэрүүдийг байгуулах түүхий эдийн нөөц хангалттай гэж үзсэн байна. Эдгээрээс одоогоор Оюутолгойн зэс, алт мөнгөний орд, Тавантолгойн коксжих нүүрсний ордод олборлох, боловсруулах үйлдвэр баригдаж, ажиллаж эхэлсэн. Мөн Нарийнсухайт, Гурвантэсийн нүүрсний орд, Ерөөгийн төмрийн хүдрийн ордууд ашиглагдаж эхлээд байна.

Хүснэгт 6. Төвийн бүсийн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн

Аймаг	Тухайн оны бүтээгдэхүүний нийт хэмжээ, сая.төг			Улсын дүнд эзлэх %		
	2012	2013	2014	2012	2013	2014
Бүсийн дүн	1 019 338,5	935 780,5	1 188 341,1	16,8	14,0	10,7
Говьсүмбэр	26 928,2	33 248,7	40 132,5	0,4	0,5	0,4
Дархан	146 213,8	191 277,5	172 334,9	2,4	2,9	1,6
Дорноговь	18 377,7	13 162,2	12 736,5	0,3	0,2	0,1
Дундговь	2 644,2	2 828,5	3 071,5	0,0	0,0	0,0
Өмнөговь	443 931,0	396 337,2	573 667,5	7,3	5,9	5,2
Сэлэнгэ	347 543,2	266 723,8	344 701,2	5,7	4,0	3,1
Төв	33 700,5	32 202,6	41 697,0	0,6	0,5	0,4

Бүсийн хэмжээнд аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээгээр Өмнөговь, Дархан-Уул, Сэлэнгэ аймгууд тэргүүлж байна. Өмнөговь аймагт уул уурхай, Сэлэнгэ аймагт уул уурхай, газар тариалан, Дархан-уул аймагт хөнгөн болон хүнд үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл тэргүүлэх салбар болон хөгжсөнтэй холбоотойгоор Уул уурхайн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрүүдээс гадна эрчим хүч үйлдвэрлэх, барилгын материалын үйлдвэрлэл, хөнгөн үйлдвэрийн салбар нэлээд байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна. Төвийн бүсийн хот суурингуудад цаашид аж үйлдвэр технологийн парк байгуулах боломжтой бөгөөд үйлдвэрлэлийн төрөлжилт бүхий нутаг дэвсгэрийн системийг бүрдүүлж кластерийн чиг хандлагаар хөгжих боломжтой гэж үзэж байна.

Хөдөө аж ахуй. Төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөрт хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодохойлохдоо: "Газар

тариалангийн гаралтай түүхий эдэд түшиглэсэн жижиг, дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх нөөц боломж ч харьцангуй илүү байна. Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг орчин үеийн өндөр технологи хэрэглэн боловсруулж, экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдвэрлэн экспортод гаргаж байх өргөн боломж байгаа юм" нь улсын газар тариалангийн тэргүүлэх бүс нутаг болохыг харуулж байна (Дүрслэл 8).

Орхон-Сэлэнгийн сав газар нь Монгол улсдаа газар тариалангийн үйлдвэрлэлээр тэргүүлэх бүс юм. Газар тариалангийн хөгжлөөрөө тэргүүлэгч Сэлэнгэ, Дархан-Уул, Төв аймгууд нь Монгол орны хөдөө аж ахуйн мужлалтаар газар тариалан хөгжүүлэх боломжтой Булган-Хэнтийн, Сэлэнгийн мужуудад багтаж байгаатай холбоотой. Харин бүс нутгийн урд хэсгээр тариалан эрхлэхэд төдийлэн тохиромжтой бус Дорнод, Говийн мужуудад Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Өмнөговь аймгууд багтаж байна (Буяндэлгэр, 2000).

малын тоо толгойн 24 % нь тус бүсэд байгаагаас
Адуу, Тэмээний тоо толгойгоор бусад бүсээс

тэргүүлдэг.


Хүснэгт 8. Төвийн бүсийн малын тоо, төрөл

	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	Тэмээ
Дархан	14.173	46.601	167.617	95.761	0.089
Дорноговь	120.832	65.436	690.742	774.991	34.792
Дундговь	105.145	45.926	1,114.848	1,141.79	28.03
Говьсүмбэр	10.192	7.363	109.135	118.002	0.611
Сэлэнгэ	79.762	196.59	698.895	495.931	0.506
Төв	330.971	289.364	2,125.718	1,432.545	2.912
Өмнөговь	66.345	16.085	397.6	1,256.272	112.741
Нийт	732.196	670.36	5,347.68	5,358.27	179.942
Улсын нийт	2,995.754	3,413.851	23,214.783	22,008.896	349.299
Улсад эзлэх %	24.44	1.96	2.3	2.43	51.5

Эх сурвалж: Үндэсний статистикийн эмхэтгэл

Улсын нийт малын тоо толгойн төрөл тус бүрээр улсын хэмжээнд эзлэх хувийг авч үзвэл: Тэмээний 51.5%, адууны 24.44%, үхэр сүрэгийн 1.96% , хонины 2.3%, ямааны 2.4% хувь нь ноогдож байна. Дархан , Сэлэнгэ , Төв аймгийн

хувьд хангай хээрийн бүсэд орших байгалийн нөхцөл сайтай бөгөөд энэ нь хүн амыг татах гол хүчин зүйлийн нэг болж өгдөг. Бүсийн малын 30%-ийг Төв аймагт оршиж байна.



Зураг 9. Төв бүсийн малын тоон нягтшил

Эх сурвалж: (Базарханд 2015)

Малын тоо толгойн нягтшилыг 100 га-д ноогдох хонин толгойд шилжүүлэн авч үзэхэд Дархан, Сэлэнгэ, Төв аймагуудад нягшил өндөртэй байгаа нь төв бүс нутаг руу малчдын шилжих хөдөлгөөн өндөр, мөн тухайн аймгууд нь байгалийн нөхцөл нөөцийн хувьд мал аж ахуй эрхлэхэд тааламжтай бүс нутагт хамаарч байгаатай холбоотой. Цаашид бүсийн хэмжээнд мал аж ахуйн салбарыг хөгжүүлэхдээ газар тариалан, уул уурхай, хот суурингийн хөгжилтэй уялдуулан орон зайн зохион байгуулалт хийж бүс, дэд бүсээр төлөвлөх шаардлагатай байна.

Төвийн бүсийн дотоод бүсчлэл



Зураг 10. Төвийн бүсийн тэнхлэгүүдийг харгалзан гаргасан загвар дэд бүсүүд

Эх сурвалж: (Базарханд 2015)

Дэд бүс тус бүрт үйлдвэрлэл аж ахуйн төрөлжилт бүхий бичил бүсчлэл тогтоох санал дэвшүүлж байна. Бичил бүс тогтоосноор оронзайн зохион байгуулалт хийхэд нутаг дэвсгэрийн онцлог ялгаа, байгаль, аж ахуйн нөхцөл нөөц, хот суурингийн чиг үүрэг зэргийг төлөвлөлтөнд харгалзах боломжийг нэмэгдүүлэхээс гадна бичил бүс бүлэг сууринг тодорхой чиг үүрэгтэйгээр төлөвлөн хөгжүүлэх боломжтой болно. Өөрөөр хэлбэл үндсэн бүсийн төлөвлөлтөнд тусгагдаагүй арга хэмжээ, харгалзаагүй нутаг дэвсгэр, орон зайн нөхцөл нөөцийн ялгаат байдлыг дэд бүсийн түвшинд, дэд бүсийн түвшинд хийгдээгүй ажлуудыг бичил бүсийн түвшинд төлөвлөн оронзайн зохион байгуулалтыг авч үзэж төлөвлөлтийг

хэрэгжүүлнэ. Дэд бүс, бичил бүсийн төлөвлөлтийн зорилго зорилт нь бүсийн ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, зорилттой бүрэн нийцэж байх албагүй ч тэдгээрийн тодорхой хэсгүүдийг шийдвэрлэх шаардлагатай. Тиймээс бүсийн дотоод бүс, түүний доторх бичил бүсүүд нь төлөвлөлтийн нэгжийн үүрэг гүйцэтгэх, бүлэг суурингууд, тэдгээрийн багтаасан засаг захиргааны нэгж сумын хамт бүс нутаг төлөвлөлтийн хамгийн бага нэгж болно. Эдгээр зорилго, зорилтод тулгуурлан нийгэм, эдийн засаг орон зайн зохион байгуулалтын дүн шилжилгээний үр дүнд үндэслэн төвийн бүсийн нутаг дэвсгэрийн нэгдсэн схемийг доорх байдалтай боловсрууллаа.

Хүснэгт 9. Төвийн бүсийн нутаг дэвсгэрийн систем.

Төвийн бүс	Дэд бүсүүд	Бичил бүсүүд	Бүлэг суурингийн төв ба хамрагдах сумд
	Дархан-Сэлэнгийн аж үйлдвэр газар	Дархан-Шарын голын бичил бүс	Бүлэг суурингийн төв нь Дархан хот, Дархан-уул аймаг бүхэлдээ, Сэлэнгэ аймгийн Орхон, Сант, Орхонтуул, Сайхан, Хушаат, Жавхлант, Ерөө,

	тариалангийн бүс		Хүдэр сумд
		Сүхбаатар-Алтанбулагийн бичил бүс	Бүлэг суурингийн төв нь Сүхбаатар хот, Түшиг, Зүүнбүрэн, Шаамар, Алтанбулаг
		Алтанбулагийн олон улсын чөлөөт худалдааны бүс	Алтанбулагийн олон улсын чөлөөт худалдааны бүс
		Зүүнхараагийн газар тариалан хүнсний үйлдвэрлэлийн бичил бүс	Мандал, Баянгол сумд
	Нийслэлийн эрчимтэй таталцал нөлөөллийн бүс	Улаанбаатарын бүлэг суурин	Улаанбаатар хот түүнд шууд татагдаж буй Төв аймгийн Алтанбулаг, Зуунмод, Батсүмбэр, Сэргэлэн, Эрдэнэ, Баян-өнжүүл сумд
		Аргалант, Баянчандмань төвт бүлэг суурингууд	Аргалант төвт бүлэг сууринд Аргалант, Цээл, Баянцогт, Угтаалцайдам, Заамар, Баянхангай, Баянчандмань төвт бүлэг сууринд Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр сумд
		Эрдэнэ төвт бүлэг суурин	Төв аймгийн Эрдэнэ Мөнгөнморьт сумд, бичил бүсийн төв нь Эрдэнэ сумын төв
		Лүн төвт бүлэг суурин	Лүн төвт бүлэг сууринд Лүн, Эрдэнэсант, Өндөрширээт, Бүрэн, Дэлгэрхаан сумд
		Багануур, Багахангай төвт бүлэг суурингууд	Багануур төвт бүлэг сууринд Багануур хот, Баяндэлгэр, Баянжаргалан, Мөнгөнморьт сумд. Багахангай төвт бүлэг сууринд Багахангай дүүрэг, Баян, Архуст, Баянцагаан сумд
	Говийн уул уурхай, аж үйлдвэр, байгаль хамгааллын бүс	Мандалговийн засаг захиргааны төвийн бичил бүс	Бүлэг суурингийн төв нь Мандалговь, хамрагдах сумд нь Сайхан-овоо, Дэлгэрхангай, Хулд, Луус, Эрдэнэдалай, Адаацаг, Дэрэн, Дэлгэрцогт, Гурвансайхан, Өлзийт
		Сайншандын засаг захиргаа, аж үйлдвэрийн бичил бүс	Бүлэг суурингийн төв нь Сайншанд, Иххэт, Алтанширээ, Дэлгэрэх, Сайхан дулаан, Өргөн, Эрдэнэ, Улаанбадрах, Замын-үүд, Зүүнбаян сумд
		Оюутолгойн зам тээврийн зангилаа, уурхайн хот орчмын бичил бүс	Бүлэг суурингийн төв нь шинээр үүсэх Оюутолгой тосгон, Ханбогд, Баян-овоо сумд, Гашуунсухайт боомтын хамт
		Даланзадгадын засаг захиргаа, зам тээврийн бичил бүс	Бүлэг суурингийн төв нь Даланзадгад, Номгон, Хүрмэн, Баяндалай, Булган, Ханхонгор, Мандал-овоо, Цогт-овоо
		Чойрын зам тээврийн зангилаа, засаг захиргааны бичил бүс	Бүлэг суурингийн төв нь Чойр, Говьсүмбэр аймгийн Шивээ-овоо, Баянтал сумд, Дундговь аймгийн Цагаандэлгэр, Говь-угтаал, Баянжаргалан, Өндөршил, Дорноговь аймгийн Даланжаргалан сумд
		Цагаан суваргын зам тээврийн зангилаа, уурхайн хот орчмын бичил бүс	Бүлэг суурингийн төв нь шинээр үүсэх Цагаансуварга уурхайн суурин, Дорноговь аймгийн Мандах, Хөвсгөл, Хатанбулаг сумд, Хангимандал боомтын хамт
		Цогтцэций зам тээврийн зангилаа, Тавантолгойн уурхай орчмын бичил бүс	Цогтцэций бүлэг суурингийн төвтэй. Шинээр үүсэх уурхайн тосгон, Манлай сумын хамт
		Гурвантэсийн зам тээврийн зангилаа, нүүрс олборлох үйлдвэрлэлийн бичил бүс	Бүлэг суурингийн төв нь Гурвантэс сум, Ноён, Сэврэй сумд, Шивээхүрэнгийн боомтын хамт.
		Замын-Үүдийн олон усын	Замын-Үүдийн олон усын чөлөөт худалдааны

		чөлөөт худалдааны бүс	бүс
--	--	-----------------------	-----

3 Дэд бүс, 16 бичил бүсийн хэмжээнд нутаг дэвсгэрийн системийг авч үзэхдээ тодорхой эрэмбийн төвийн үүрэг гүйцэтгэх хотуудын чиг үүргийг тусган авч үзэх шаардлагатай байна. "Хот тосгоны эрхзүйн

байдлын тухай" хуулиар хот сууринг хүн амын тоонд тулгуурлан ангилсан ч улс бүсийн хэмжээнд гүйцэтгэж буй үүргийг хангалттай авч үзээгүй.


Хүснэгт 10. Төвийн бүсийн зарим томоохон хот, суурингуудын чиг үүрэг

	Хот суурингийн чиг үүрэг	Хот
1	Олон үүрэгтэй хот	Улаанбаатар
2	Засаг захиргаа-үйлдвэрлэл-үйлчилгээ давамгайлсан хот	Дархан
3	Засаг захиргаа – үйлчилгээний үүрэг давамгайлсан хот	Сайншанд Мандалговь Даланзадгад Зуунмод Налайх
4	Үйлдвэрлэл-үйлчилгээний үүрэг давамгайлсан хот	Багануур Зүүнхараа Хөтөл
5	Үйлчилгээ- засаг захиргааны үүрэг давамгайлсан хот	Бор-Өндөр Чойр

Төвийн бүсийн хот суурингууд нь бусад бүсийн хот суурингуудын чиг үүрэгтэй харьцуулахад засаг захиргааны нэгжийн төвийн үүрэг гүйцэтгэхээс гадна үйлдвэрлэл, үйлчилгээ, тээврийн үүргийг хослуулсан давуу талтай. Мөн олон үүрэг бүхий нийслэл Улаанбаатар хот нэг бүсэд багтан, хоёр хөршийг холбосон гол тэнхлэгийн дагуу оршиж байгаа нь байршлын хувьд харьцангуй илүүтэй болгож байна. Төвийн бүс нь нэгдмэл нэг нутаг дэвсгэрийн систем бөгөөд дотроо дэд системүүдтэй, дэд системүүд нь аль нэг эрэмбийн төвүүдтэй байна. Нийт нутаг дэвсгэрийг дэд бүсүүдэд хуваан, дэд бүсийг бичил бүс, бүлэг суурингийн тогтолцоод хуваах нь бүс нутгийн хөгжлийн дэлхий нийтийн хандлага болоод буй “функциональ бүс нутгууд”-ыг тодорхойлох буюу бүс нутгийн хөгжлийн чиглэл, нийгэм эдийн засагт гүйцэтгэх үүргийг тодорхойлоход чиглэгдсэн. Үүнийг: “газар нутгийн функциональ нэгдмэл болон харилцан хамааралтай байдлыг хангасан, тухайн улсынхаа нөхцөл, байдалд нийцсэн шалгууруудыг баримтлалсан газар зүйн нутаг дэвсгэрийн хуваарь” гэж ойлгож болно. Эдийн засгийн Төвийн бүсийн дотоод бүсчлэлийг оновчтой тогтоох нь бүс нутгийн хөгжлийн гол зорилго болсон “Бүс нутаг дахь хот, хөдөөгийн ялгааг багасгах таатай орчинг бүрдүүлэх, байгалийн баялаг, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарын нөөц бололцоог тухайн бүс нутгийн онцлог давуу тал, чадавхитай нь

уялдуулан дээд зэргээр үр ашигтай ашиглах, үүний үр дүнд хүн дэвшлийг дэмжих” үндсэн чиглэлийн бодлогыг тодорхойлоход чухал ач холбогдолтой юм. Төвийн бүсийг дэд бүсэд, дэд бүсийг бичил бүс, бүлэг суурингийн тогтолцоонд хуваах нь бүс нутгийн хөгжлийг төлөвлөхөд илүү үр дүнтэйн дээр, цаашид бичил бүс, бүлэг суурингуудад үйлдвэрлэл, үйлчилгээний кластеруудыг төлөвлөж хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх болно.

Монгол улсад 1996 онд боловсруулагдан УИХ-д өргөн барьсан хүн амын нутагшил, хөгжлийн ерөнхий төслөөр дэвшүүлэн тавигдсан бүс нутгийн төлөвлөлт, зохион байгуулалтын төслүүд, 2001 онд батлагдсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал зэрэгт тусгагдсан судалгаа шинжилгээний ажлуудыг нэгтгэн дүгнэж, нэмж судлан, бичил бүс, бүлэг сууринг хөгжүүлэх кластерыг харгалзан Төвийн бүсийн дотоод бүсчлэлийн тодорхой хувилбарыг санал болгож байна. Мөн эдийн засгийн Төв бүсийн хөгжлөөр тэргүүлэгч гол бүс болох Нийслэлийн эрчимтэй таталцал нөлөөллийн бүсийн хилийг “Нийслэл Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлал”, Улаанбаатар, 2002 он зэрэг хөтөлбөрийн үзэл баримтлалыг өөрчилж Төв аймгийн хилээр байхаар тогтоож, тус бүс дэх бичил бүс, бүлэг суурингуудын таталцалыг шинэчлэн тогтоох санал оруулж байгаа болно.



Зураг 11. Эдийн засгийн төвийн бүсийн таталцал

Эх сурвалж: (Базарханд 2015)

1. Нийслэлийн эрчимтэй таталцал нөлөөллийн бүс
2. Говийн
3. Дархан Сэлэнгийн

Бүс нутгийн бодлого нь “Тухайн улс орны бүс нутгууд, ялангуяа нийслэл хот, түүнээс алслагдсан бүс нутгууд хоорондын тэнцвэрт бус байдлыг багасгах арга хэмжээ юм” (Роутледж 2002) хэмээн авч үздэг нь Төвийн бүсийн хувьд ч тодорхой харагдаж байна. Учир нь төвийн бүсэд 2000 оноос өмнө хөгжлийн тодорхой чиг үүрэг давамгайлсан бичил бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэх боломж хязгаарлагдмал байсан. Түүнээс хойш говийн бүсэд ашигт малтмалын ордууд олноор нээгдэж уурхайнууд байгуулагдаж, тэдгээрийг дагасан үйлдвэрлэл, үйлчилгээ бичил бүсүүдэд болон дэд бүсэд цаашлаад нийт Төвийн бүсийн хэмжээнд бий болж хөгжиж эхэлсэн.

Дүгнэлт

Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг судлан үзэж бүс нутгийн дотоод дэд бүсийг тогтоох аргазүйг боловсруулсан. Төвийн бүсийн дотоод бүсчлэлийг үйлдвэр, аж ахуйн төрөлжилт бүхий бүлэг суурингуудыг багтаасан Дархан Сэлэнгийн аж үйлдвэр газар тариалангийн, Нийслэлийн эрчимтэй таталцал нөлөөллийн, Говийн уул уурхай байгаль хамгааллын дэд бүсүүд ялгарч байна. Нийслэлийн эрчимтэй таталцал нөлөөллийн бүс нь төв бүс, Дархан Сэлэнгийн болон Говийн бүс нь хязгаар бүс болж дэд бүсүүд нь хоорондоо автозам төмөр замын олон үүрэгт тэнхлэгээр холбогдож байгаа нь тус бүс нь тэнхлэгт төв хязгаарын загвараар хөгжих боломжтой гэж дүгнэж байна. Дэд бүсүүдийг бүлэг суурин, аж ахуйн төрөлжилт бүхий 16 бичил бүстэйгээр төлөвлөн хөгжүүлэх боломжтой байна. Төвийн бүсийн хүрээнд 8 бичил бүс Ази-Европыг холбосон гол тэнхлэгт бүрэн таталцсан, 4 бичил

бүс дэд тэнхлэгийн нөлөөлтийн бүсэд багтаж байна. Төвийн бүсийг дэд бүсэд, дэд бүсийг бичил бүс, бүлэг суурингийн тогтолцоонд хуваах нь бүс нутгийн хөгжлийг төлөвлөхөд илүү үр дүнтэйн дээр, цаашид бичил бүс, бүлэг суурингуудад үйлдвэрлэл, үйлчилгээний кластеруудыг төлөвлөж хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх болно.

Номзүй

Гранберг А. Г., 2003, Основы региональной экономики. Высшая школа экономики, Москва
Гранберг А. Основы региональной экономики. М., 2000.

Степанова М.В./М. /Под ред. 2000. Региональная экономика.

Буяндэлгэр Ч., 2000, "Монгол улсын төв хэсэг (Төвийн болон Хангайн бүсийн) -ийн мал аж ахуйн туухий эдийн хуваарилалтын нутаг дэвсгэрийн онцлог" докторын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар.

Базарханд Ц., 2015, "Нийслэлийн бүс нутгийн орон зайн төлөвлөлтийн үндсэн асуудлууд" докторын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар.

Галбадрах С., 2006, "Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн удирдлагын асуудалд" докторын зэрэг горилсон бүтээл, Улаанбаатар.

Батцэнгэл В., ба бусад, 2010 "Төвийн бүсд нэн түрүүнд хөгжүүлэх хот суурингийн судалгаа" Улаанбаатар.

Давааням,С ба Бямбаа,Д., 2001, "Төвийн бүсийн хүн амын нутагшилт, суурьшил,

шилжилт хөдөлгөөн, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа".

Цэдэндамба,Л., 2011, "Бүсчилсэн хөгжлийн бодлогын онол, аргазүйн үндэс, Улаанбаатар.

Ширнэн,Г. ба Базаргүр,Д., 1987, "БНМАУ-ын хөдөө аж ахуйн газарзүй" Улаанбаатар.

Баянтөр,М, О.Сүхбаатар ба бусад., 1971, "БНМАУ-ын хүн амын газарзүйн зарим асуудлууд".

Нийслэлийн зураг төслийн хүрээлэн., 2013, Үндэсний статистикийн хороо "Монгол улсын статистикийн эмхтгэл 2000 - 2014", Улаанбаатар.

Нийслэлийн зураг төслийн хүрээлэн., 2013, "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага III боть", Улаанбаатар.

Нийслэлийн зураг төслийн хүрээлэн., 2013, "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага IV боть", Улаанбаатар.

Пүрэвцэрэн, Г., 2001, "Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө", Улаанбаатар.

ДБХС, 2000 "Бүс нутгийн хөгжлийн төсөл боловсруулах аргачилсан заавар" УББ 11- 201-00.

Монгол улсын хүн амын нутагшил суурьшдын схем, Улаанбаатар.

УИХ, 2003 "Монгол улсын бүсүүдийн хөгжлийн дунд хугацааны стратеги (2010он хүртэл)" УИХ-ын тогтоол,Улаанбаатар.